



Үйл ажиллагааны тайлан



MONGOLIAN NATIONAL CLIMBING FEDERATION

**МОНГОЛЫН УУЛЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ
2016-2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛГААНЫ ТАЙЛАН**



Ерөнхийлөгч Б.Тулга



Хүндэт Ерөнхийлөгч
Ж.Баянцагаан



Сургалт аюулгүй ажиллагааны хороо хариуцсан
Дэд Ерөнхийлөгч Т.Батзул



Өндөр уул, хайкинг хороо хариуцсан
Дэд Ерөнхийлөгч С.Алдархишиг



Тэмцээнт төрөл хариуцсан
Дэд Ерөнхийлөгч Б.Золжаргал



Үйл ажиллагааны тайлан



Цол зэргийн зөвлөлийн дарга

Б.Гангаамаа



Удирдах зөвлөлийн гишүүн

А.Батсүх



Удирдах зөвлөлийн гишүүн

М.Бүрэнтөгс



Удирдах зөвлөлийн гишүүн

С.Балжинням



Удирдах зөвлөлийн гишүүн

Н.Батсайхан



Удирдах зөвлөлийн гишүүн

Т.Баттулга



Удирдах зөвлөл, Ахмадын зөвлөл

Д. Чагнаа



Ерөнхий нарийн бичгийн дарга

Б.Эрдэнэцэцэг




Ц.Цогзолмаа



Хяналтын зөвлөлийн гишүүн

Ш.Мөнхбаатар





МОНГОЛЫН УУЛЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО 2016 ОНЫ ТАЙЛАН

1. 03-р сарын 11-нд

Монголын Уулчдын Үндэсний Холбооны төлөөллүүд Эрүүл мэнд, спортын яамны харъяа Биеийн тамир, Спортын хөгжлийн төвийн удирдлагуудтай хамтран ажиллах чиглэлээр уулзаж санал солилцлоо.



Холбооны тэмцээнт төрөл хариуцсан дэд ерөнхийлөгч, ерөнхий нарийн бичгийн дарга, спорт авиралтын хорооны дарга нар Монголын үндэсний спорт авиралтын холбооны удирдлагуудтай уулзаж хамтран ажиллах санал солилцлоо

Холбооны төлөөлөл Батлан Хамгаалахын Сургуулийн захирал хошууч генерал Я.Чойжамцтай уулын спортын төрлүүдийг сургалтын хөтөлбөрт оруулах, уулын аврах ажиллагааны тогтолцоог бэлтгэл хүчний сургалтын хөтөлбөрт оруулах, эрдэм шинжилгээний ажлууд хийх зэрэг дээр хамтран ажиллах асуудлаар уулзаж санал солилцлоо






2. 03-р сарын 27-нд

Өмнөговь аймгийн Залуучуудын холбоо, Монголын Уулчдын Үндэсний холбоо хамтарч өнгөрөгч амралтын өдөр Гурвансайхан уулын үзэсгэлэнт газар болох мухар шивэртийн аманд мөсөнд авиралтын анхдугаар тэмцээнийг зохион байгууллаа.

Өмнөговь аймагт өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх таатай боломжийг нээх үүднээс анх удаа зохион байгууллаа. Тэмцээн 8м өндөр 85 градус налуу мөсөнд нэг насны ангиллаар эрэгтэй, эмэгтэй гэсэн хоёр төрлөөр зохион байгуулагдаж, хувийн болон багийн гэсэн нийлбэр дүнгээр шилдэг авирагчийг тодрууллаа. Мөсөнд авиралтын анхдугаар тэмцээнд нийт 30 гаруй сонирхогч хурд хүч авхаалж самбаагаа сорин уралдав.



3. 04-р сарын 18-нд

Монголын Уулчдын Үндэсний холбооны Ерөнхийлөгч Б.Тулга, Удирдах зөвлөлийн гишүүд Хайкинг клубуудын Тэргүүнүүд болон төлөөллүүдтэй уулзалт хийлээ. Уулзалтаар Холбооны үйл ажиллагаа, зорилго, төлөвлөгөөг танилцуулж Хайкинг клубуудын үйл ажиллагааг хэрхэн уялдуулах талаар санал солилцлоо.





4. 04-р сарын 19-нд

БОНХЯ-ны сайд Н.Батцэрэгтэй уулзалт хийв. Уулзалтаар Алтай Таван Богдын байгаль орчны бохирдлын асуудлаар санал солилцон төслийн шугамаар ариун цэврийн байгууламжийн тохижолтын асуудлаар тодорхой хүсэлт гаргаж дэмжүүлэхээр болсон



5. 05-р сарын 1-нд

Монголын Уулчдын Үндэсний Холбооны Спорт авиралт, хаданд авиралтын хороо, Мөсөнд авиралтын хорооноос зохион байгуулж буй энэхүү уулзалтаар спорт авиралт, мөсөнд авиралтыг хөгжүүлэх хүрээнд Холбооноос баримталж буй бодлого, төлөвлөгөө, тэмцээний дүрмийн төсөл, олон улсын тэмцээнд хэрхэн оролцох тухай зэрэг мэдээллийг тамирчдад өгч чөлөөтэй санал солилцов.





6. 05-р сарын 01-нд

Холбооны Аюулгүй ажиллагаа, сургалтын хорооны Respect the Mountains буюу "уул, усаа хүндэл" уриан дор зохион байгуулагдах сар бүрийн уулзалт, лекцийн анхны уулзалтыг тус хорооны дарга уулчин, шүхэрчин, цаначин Жастин Талли Guided by mountain нэрийн доор удирдан явууллаа. Тэрээр өөрийн уулын спортод хэрхэн дурлах болсон, уулнаас юу сурсан зэрэг туршлагаа хуяалцахаас гадна АНУ-ын уулын бүсийн тухай сонирхолтой мэдээллүүдийг өгсөн билээ



7. 05-р сарын 02-нд

Уулын спортын ууган мастер, Олон улсын хэмжээний мастер Д. Оюунбатын нэрэмжит 2016 оны Эрдэнэт хотын хадан авиралтын өсвөр үеийн V-дах удаангийн аврага шалгаруулах тэмцээнд нийт 6 цогцолбор сургуулийн 11 баг 88 тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин амжилттай сайн оролцлоо. Тэмцээнийг Орхон аймгийн биеийн тамир спортын газар, Уулын спортын ууган мастер ОУХМ Д.Оюунбат багш, Эрдэнэт Уулчдын Холбоо, Эрдэнэтийн Уулын Спортын Мастерууд болон Уулчид амжилттай сайн зохион байгууллаа.



8. 05-р сарын 06-08-нд

БНХАУ-ын Наньжин хот Спорт авиралтын Дэлхийн цомын тэмцээнд 2 тамирчин оролцуулсан.





9. 05-р сарын 21-22 нд

Уулын спортын ууган мастер Ядамын Жанцангийн нэрэмжит спорт авиралтын улсын аварга шалгаруулах V дугаар тэмцээнийг олон улсын тэмцээн зохион байгуулах стартын дагуу амжилттай зохион байгуулсан. Тэмцээнд нийт 14 багийн 110 тамирчин оролцов.



10. 05-р сарын 28-нд

Уулын спорт сонирхогч хайкинг клубын гишүүдэд зориулсан сургалтын зохион байгуулав.





11. 07-р сарын 17-нд

Монголын Уулчдын Үндэсний Холбоо нь 2016 оны 6-р сард Олон улсын уулын холбооны / UIAA - International Climbing and Mountaineering Federation / гишүүн, Азийн уулын холбооны /UAAA – Union of Asian Alpine Associations/ гишүүн БНСУ-ын 71 жилийн түүхтэй Corean Alpine Club-тай хамтран ажиллах САНАМЖ БИЧИГ зурж хамтын ажиллагаагаа эхлүүлсэн билээ. Бидний урилгаар Corean Alpine Club-ын мэргэжлийн 4 сургагч багш, 4 залуу уулчин, 32 уулын спорт сонирхогч хүүхдүүд Монгол улсад зочилж туршлага солилцох, сургалт, уулзалт амжилтай зохион байгуулав.



12. 8-р сарын 3-6

БНХАУ-ын Дуюун хот Спорт авиралтын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд 4 тамирчин оролцуулсан





13. 08-р сарын 10-18-нд

Аюулгүй ажиллагаа, сургалтын хорооны анхны олон улсын сургалт амжилттай зохион байгуулагдлаа. [Alaska Powder Descents Heli-skiing](#) -ийн үүсгэн байгуулагч/уулын хөтөч/Сургагч багш Dr. Kevin Krein энэхүү сургалтыг удирдан явууллаа.



Монголын Уулчдын Үндэсний Холбоо болон Wild Nature Sports ТББ хамтран АНУ-ын Аляск мужийн Alaska Powder Descent уулын аялал, аврах ажиллагаа, уулын цана, нисдэг тэрэгнээс цанаар гулгах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулдаг байгууллагын үүсгэн байгуулагч, хөтөч, сургагч багш Кевин Крейныг Монгол улсад урин Алтай Таван Богд байгалийн цогцолборт газарт Потанины мөсөн гол дээр АНГАЛААС АВРАХ СУРГАЛТ 2016 оны 08 сарын 3-13 өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

14. 2016.08.13

Холбооны шүүгчдийн зөвлөлийн дарга Д.Батболд, Хяналтын зөвлөлийн гишүүн Ч.Бат-Эрдэнэ, Маркетингийн хорооны гишүүн н.Оюунцэцэг, Удирдах зөвлөлийн гишүүн Доктор А.Батсүх, Аюулгүй ажиллагаа, сургалтын хорооны гишүүн Б.Эрдэнэцэцэг, Удирдах зөвлөлийн гишүүн Л.Бүрэнтөгс.





15. 2016.08.25

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын дарга Монгол улсын гавьяат тамирчин Ц.Шаравжамцтай Холбооны Ерөнхийлөгч Б.Тулга, Дэд ерөнхийлөгч Б.Золжаргал нар ажлын уулзалт хийж уулын спортыг хөгжүүлэх асуудал, түүн дотор шинэхэн олимпын төрөл болох спорт авиралтыг хөгжүүлэх асуудлаар уулзаж харилцан санал солилцлоо.



16. 08-р сарын 26-27 нд

БНХАУ-ын Шанхай хот, Спорт авиралтын Оюутны Дэлхийн аварга шалгаруулах анхдугаар тэмцээнд Сутайн бор клубын тамирчин Н.Хэрлэн, Б.Сайханжаргал нар амжилтай оролцов.





17. 08-р сарын 27-28 нд



2016 оны Хаданд авиралтын улсын аварга шалгаруулах тэмцээнийг Төв аймаг, Борнуур сумын нутагт байрлах “Дуган хад” байгалийн хаданд 2 өдрийн турш амжилттай зохион байгуулсан. Хаданд авиралтын Улсын аварга шалгаруулах тэмцээнд зохион байгуулагчдийн 20

гишүүн, 12 багийн болон хувиараа оролцож байгаа тамирчид гэсэн нийт 93 тамирчид оролцлоо. Тэмцээнд оролцсон тамирчид маань 42 багц медалийн төлөө хурдны авиралт болон техникийн авиралтын хоёр төрлөөр бүтэн 2 өдрийн турш өрсөлдөж дүнгээ гаргасан.

18. 10-р сарын 03 нд

Аствишн ХХК, МУҮХолбоо хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Энэхүү хамтын ажиллагаа нь холбооны үйл ажиллагааг ивээн тэтгэж 45 сая төгрөгийн үнэлгээ бүхий “Уулын спортын удирдлагын систем”-ийн хөгжүүлэлт хийж гүйцэтгэх, холбооны эзэмшилд шилжүүлэх, засвар үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцаа, хамтын



ажиллагааг зохицуулахад оршино. Энэхүү систем нэвтэрснээр уулын спорт сонирхогч, тамирчдын нэгдсэн бүртгэл,



Үйл ажиллагааны тайлан

мэдээллийн сан бий болох ба тамирчдын ур чадвар, чансаа тодорхойлох, тамирчдын гаргасан амжилтын бүртгэл зэрэг цахимаар хийгддэг болно.

19. 11-р сарын 07 нд

Уулын спортын Улаанбаатар аялагч клуб санаачлан зохион байгуулж буй БАГА НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН СПОРТ АВИРАЛТЫН ТЭМЦЭЭН 2016 оны 11-р сарын 27-ны НЯМ гаригт зохион байгуулагдаж. Монголын Уулчдын Үндэсний Холбоо тус тэмцээнд техникийн болон мэргэжлийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаа.



20. 11-р сарын 09 нд

Холбооны Ерөнхийлөгч Б.Тулга, дэд ерөнхийлөгч Б.Золжаргал нар Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдтой уулзаж дараах асуудлуудаар санал солилцлоо.

1. Богд хан уулын алхалтын замуудын маршрутыг тодорхой болгож газрын зурагжуулах, зам засаж дэд бүтэцийг сайжруулах;
2. Өвөл мөсөнд авиралтын байгууламж, зун спорт авиралтын олон улсын стандартын зам бүхий спорт авиралтын хана байгуулах төслийг хамтран хэрэгжүүлэх.



21. 10-р сарын 17

Олон улсын спорт авиралтын холбооны Итали улсын Турин хот дахь төв оффист уулзалт хийв. Уулзалтаар МУҮХ-ны танилцууллага, стратеги төлөвлөгөөг танилцуулж спорт авиралтын стандарт хана барих, олон улсын сургалт хөтөлбөрт тамирчин дасгалжуулагч сургах тухай анхан шатны уулзалт хийсэн.



22. 11-р сарын 16-20 нд

Монголын уулчдын үндэсний холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, Өндөр уулын авиралт & Хайкинг хариуцсан Дэд ерөнхийлөгч С.Алдархишиг Непал улсын Катманду хотноо 11-р сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулагдах 2016 оны Азийн уулын холбооны чуулганд /General Assembly of the UAAA - Union of Asian Alpine Associations/ оролцолоо.



Энэхүү хуралаар МУҮХ нь Азийн уулын холбооны гишүүнээр элсэх хүсэлт өгсөн байсан ба тус хүсэлтийг шийдвэрлэжээ. Мөн 2018 оны Ерөнхий ассамблейг Олон улсын уулын холбоо /UIAA/-ны Ерөнхий ассамблейтэй хамтад нь Монгол улсын Улаанбаатар хотод зохион байгуулах эрхийг авлаа.



23. 12-р сарын 6-15

ОХУ-ын Киров хотноо Олон улсын уулын холбоо /UIAA/, Оросын уулын холбоо /RMF/-ын хамтран зохион байгуулж буй Мөсөнд авиралтын залуучуудын сургалтанд 2 тамирчин оролцуулсан.





МОНГОЛЫН УУЛЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО 2017 ОНЫ ТАЙЛАН

1. 1-р сарын 3-9 -нд

Олон улсын уулын холбоо / [UIAA - International Climbing and Mountaineering Federation](#) /-с зохион байгуулж буй Мөсөнд авиралтын олон улсын шүүгчийн эрх олгох сургалт БНХАУ-ын Бээжин хотод Хятадын уулын холбооны дэмжлэгтэйгээр зохион байгуулагдаж. Тус сургалтанд манай холбооны Шүүгчдийн зөвлөлийн дарга Д.Батболд, Мөсөнд авиралтын хорооны гишүүн С.Дэлгэрмөрөн нар оролцлоо.



2. 1-р сарын 3-9 -нд

Мөсөнд авиралтын Дэлхийн цомын тэмцээн зохион байгуулагдаж энэхүү тэмцээнд Монгол улсаа төлөөлөн [Sutain Bor Mountaineering Club](#)-ийн тамирчин Спортын дэд мастер Н.Хэрлэн, [Улаанбаатар аялагч клуб](#)-ийн тамирчин Д.Отгонхүү, Холбооны тэмцээнт төрөл хариуцсан Дэд ерөнхийлөгч Б.Золжаргал ахалж Монгол улсаа төлөөлөн оролцлоо.





3. 1-р сарын 19

Монголын уулчдын үндэсний холбоо үндэсний шүүгч бэлтгэх сургалтыг Олон улсын уулын холбоо /UIAA/-ны тэмцээний дүрэмийн дагуу зохион байгуулсан. Сургалтанд нийт 11 шүүгч хамрагдсан. Сургалтын практик сургалтыг ОУУХ-ны эксперт Надежда Лауниц, Василий Терехин нар Мөсөнд авиралтын УАШТ-ний үеэр удирдаж ажилсан.

Сургагч багш: Мөсөнд авиралтын хорооны гишүүн, тэмцээний ахлах шүүгч С.Дэлгэрмөрөн, Шүүгчдийн зөвлөлийн дарга, тэмцээний шүүгч Д.Батболд



4. 1-р сарын 21-22

“Ice Challenge-2016” Мөсөнд авиралтын улсын аварга шалгаруулах VI удаагийн тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд нийт 15 багийн 85 тамирчин оролцов.





5. 1-р сарын 16-23 нд

“Ice Challenge 2016” Тэмцээнд Олон Улсын Уулын Холбоо /UIAA/-ийн Мөсөнд авиралтын хорооноос томилогдсон:

- Эксперт/шүүгч Надежда Лауниц
- Зам тавигч Василий Терехин нар хүрэлцэн ирсэн



6. 2-р сарын 09 нд

Монголын Уулчдын Үндэсний Холбооны Хайкинг хорооноос санаачлан зохион байгуулж буй нийт гишүүн байгууллага, дэмжигч, хамтрагч байгууллагуудад зориулсан Fresh MOUNTAIN Day нэртэй спорт арга хэмжээнд нийт гишүүн байгууллагуудыг оролцохыг урьж байна.



7. "ДӨРВӨН БЭРХ" ЦОМ

Монголын Уулчдын Үндэсний Холбооны 2017 оны 2-р сарын 9-ний өдрийн Удирдах зөвлөлийн хурлын 2017/04 тоот тогтоолоор "Дөрвөн бэрх" цомыг бий болгон тухайн цомыг олгох журамыг баталлаа. "Дөрвөн бэрх" цомны зорилго нь Уулын спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн уулын спортын хөгжилд хувь нэмрээ оруулах, уул усаа хүндлэх эрхэм зорилгын хүрээнд Монгол Алтай нурууны ноён оргил Хүйтэн /д.т.д 4374 м/, Хангайн нурууны ноён оргил Отгонтэнгэр /д.т.д 4008 м/, Хэнтийн нурууны ноён оргил Асралт /д.т.д 2799 м/, Соёны нурууны ноён оргил Мөнхсарьдаг /д.т.д 3491 м/ оргилуудад тус тус амжилттай авиралт хийсэн уулчныг батламжлах, улмаар уулын спортыг олон нийтэд сурталчилахад оршино. Монгол орны 4 нурууны ноён оргилуудад амжилттай авиралт хийсэн иргэдэд нээлттэй олгох энэхүү цом нь насан туршид хүчинтэй байх тул энэхүү журам батлагдсан өдрөөс өмнөх амжилтуудыг тооцох юм.





8. 3-р сарын 5-8

ОХУ Киров хот: Мөсөнд авиралтын ОХУ-ын АШТэмцээнд тамирчин Д.Отгонхүү оролцов



9. 3-р сарын 8-11



БҮРЭН ЭРХТ ГИШҮҮН БОЛЛОО

Канад улсын Квебек хотноо 2017 оны 3 дугаар сарын 8-наас 11-ний өдрүүдэд Олон Улсын Спорт Авиралтын Холбоо /ОУСАХ буюу IFSC ред./ Ерөнхий Ассамблей амжилттай зохиогдлоо. Энэхүү Ерөнхий Ассамблейд нийт 45 гишүүн орны холбоод оролцов.

Монголын Уулчдын Үндэсний Холбоог төлөөлөн тус холбооны тэмцээнт төрөл хариуцсан Дэд ерөнхийлөгч хатагтай Б.Золжаргал томилогдон амжилттай оролцов. Монголын Уулчдын Үндэсний Холбоо нь өдгөөгөөс 10 жилийн өмнө ОУСАХ буюу IFSC-ны 2007 оны 1-р сарын 27-ны өдрийн Ерөнхий Ассамблейгаар тус холбоонд Аспирант /хуучин нэрээр/ гишүүнээр, одоогийн дүрмээр Дэд /Associate member/



гишүүнээр элсэж байсан түүхтэй билээ. Монголын Уулчдын Үндэсний Холбооноос ОУСАХ буюу IFSC-нд Бүрэн эрхт /Full member/гишүүнээр элсэх хүсэлтээ 2016 онд гаргаад байсан юм. Тэгвэл энэ удаагийн Ерөнхий Ассамблейн хуралдаанд оролцсон гишүүн холбоодын санал нэгтэй шийдвэрээр Бүрэн эрхт гишүүн боллоо. Энэ удаагийн Ерөнхий Ассамблейн бас нэг онцлог бол 4 жил тутамд зохиогддог Холбооны удирдах баг/ Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид, Ерөнхий нарийн бичгийн дарга, Европ, Америк, Ази, Австрали тивүүдийн зөвлөлийн Ерөнхийлөгч, хороодын дарга нар/-ийн сонгууль амжилттай болсон явдал байв. Түүнчлэн холбооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулан, санхүүгийн гүйцэтгэл, ирэх жилийн төсөв, тивүүдийн зөвлөлүүдийн тайлан, 2020 оны Токиогийн олимп, 2018 оны Буэнос-Аэросын Залуучуудын Олимпын талаар нарийвчлан хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Уулын спортын нэгэн төрөл болох Спорт авиралтын төрөл нь 1985 оноос эхлэн хөгжиж ирсэн залуу спортуудын нэг хэдий ч 2020 оны Токиогийн Олимпод албан ёсоор багтаж их спортын гэр бүлд багтаад байна. Өдгөө дэлхий даяар нийт 35 сая хүн энэ спортоор сонирхогчийн болон мэргэжлийн түвшинд хичээллэдэг гэсэн тоо мэдээ бий.

10. 4-р сарын 4 нд

Монголын Уулчдын Үндэсний Холбооны удирдлагын төлөөлөл Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ц.Сандуй болон Нийслэлийн Аялал Жуулчлалын Газрын төлөөлөлтэй ажлын уулзалт хийж дараах ажлуудыг 2017-2020 онд хамтран хийж Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан ажиллахаар боллоо. Үүнд:

1. Нийслэлийг тойрсон 4 хайрханы явган аялал, алхалтын замуудыг тракжуулах, тохижуулах, газрын зурагжуулах, хогны менежмент, бие засах газар байгуулах зэрэг ажлын хүрээнд шат дараалсан төсөл хэрэгжүүлэх;
2. Спорт авиралт болон Мөсөнд авиралтын байгууламж барих;
3. Олон улсын уулын холбоо /UIAA/ -ын Respect the Mountains төслийн хүрээнд Цэцээ гүн оргил дээрх хадан дээрх бичвэрүүдийг арилгах ажлыг эхлүүлж, гүйцэтгэх;
4. Богд уул болон бусад хайрхануудын аялал, явган аялалуудын маршрут, мэдээлэл, гарын авлага бүхий гарын авлага, хэвлэмэл бүтээгдэхүүнээс олох орлогыг тусгай санд төвлөрүүлэн, тухайн сангаас уулын алхалтын замууд дахь бие засах газар, хоггүй байлгах менежментийн зардалд зарцуулах, зохион байгуулах;



11. 4-р сарын 9-нд

НИТХ, Нийслэлийн аялал жуулчлалын газартай хамтран хийхээр төлөвлөөд буй Нийслэлийн хүрээлэн буй 4 хайрхан, тэр дундаа Богдхан уулын алхалтын замуудыг баталгаажуулах, газрын зурагжуулж, тохижуулах ажлын хүрээнд Холбооны удирдлагын баг Манзушир-Зайсан 18 км замаар алхалт хийж тухайн замын маршрутыг тодрууллаа.



12. 4-р сарын 22-нд

Спорт авиралтын 2017 оны Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулав. 12 клубийн 48 тамирчин оролцов



13. 4-р сарын 30-нд

"Саммит" клубын санаачлагаар 4 дэх жилдээ уламжлал болон зохион байгуулагдаж буй "Дуган хад - 2017" 45 км-ын уртын алхалтыг энэ жил 2 дахь жилдээ Монголын Уулчдын Үндэсний Холбоо хамтран зохион байгуулалаа. Энэхүү арга хэмжээнд Орхон аймгийн "Хамтдаа" клуб, Говь-Алтай аймгийн "Сутайн бор" клуб, "Хамтдаа алхацгаая" клуб, "UB Hiking" клуб, "Саммит" клуб, "Монгол хайкинг" клуб, ЦЕГ-ын Шуурхай удирдлагын төв, Монголын Уулчдын Үндэсний Холбоо зэрэг 8 байгууллагын болон хувиараа бүртгүүлсэн 130 алхагч Төв аймгийн Баян Чандмань сумаас "Дуган хад" амралт хүртэл 45 км зайг амжилттай тууллаа. Энэхүү арга хэмжээг дэмжиж МУГТ, уулын спортын ОУХМ, Монгол улсын анхны Seven summiteer Б.Гангаамаа хүрэлцэн ирж оролцсонд зохион байгуулагчид, нийт оролцогчид баяр хүргэж, талархалаа илэрхийлсэн юм. Монголын Уулчдын Үндэсний Холбооны Шүүгчдийн зөвлөлийн гишүүн, ОУХМ Машбат, Эрүүл мэнд, Сургалт болон





Үйл ажиллагааны тайлан

Маркетингийн хорооны гишүүд дэмжиж алхацгаав. Жил бүр улам өргөжиж, өндөр түвшинд зохион байгуулагдах болсон тус уртын алхалтыг амжилттай Ерөнхий зохион байгуулагчаар ажилласан [Summit mountaineering & climbing club](#) -ын хамт олонд баяр хүргэе!


14. 5-р сарын 13-14 –нд

Уулын спортын ууган мастер Я.Жанцангийн нэрэмжит 2017 оны Спорт авиралтын Улсын аварга шалгаруулах VI тэмцээнийг “Сутайн бор” клубтэй хамтран зохион байгуулсан. 13 клубын 93 тамирчид оролцов



15. 5-р сарын 27нд

“УРСА” Спорт бэлтгэлийн төв: Сэтгүүлдчийн дундах Спорт авиралтын нээлттэй тэмцээнийг Монголын Үндэсний Олимпийн Хороо, Монголын Уулчдын Үндэсний Холбоо, Монголын Спортын Сэтгүүлчдийн Холбоо хамтран зохион байгуулав. 10 телевиз, сониний 19 сэтгүүлчид оролцов





16. 5-р сарын 30-аас 6-р сарын 3


2017 оны 5-р сарын 30-аас 6-р сарын 3-ны өдрүүдэд Монгол улсад Азийн уулын холбооны /UAAA/ зөвлөгөөн /council meeting/ зохион байгуулагдав. Тус зөвлөгөөнд Монголын Уулчдын Үндэсний Холбоог төлөөлж Дэд ерөнхийлөгч С.Алдархишиг оролцож байна. Зөвлөгөөнд 8 улсын 14 уулын спортын холбоод хүрэлцэн иржээ.



17. 6-р сарын 4 нд

Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн аялал жуулчлалын холбооноос зохион байгуулдаг Улаанбаатар 2017 Үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэн 6-р сарын 3-4-нд Сүхбаатарын талбайд зохион байгуулагдлаа.

Үзэсгэлэнд Монголын Уулчдын Үндэсний Холбооны хайкинг хороо, холбоог төлөөлж гишүүн клуб Улаанбаатар аялагч клуб уулын алхалтыг сурталчилж, мөн Дэд ерөнхийлөгч С.Алдархишиг Өндөр уулын аялал, авиралтыг сурталчилан оролцлоо.





18. 6-р сарын 7 нд

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар болон БНХАУ-ны Спортын ерөнхий газрын хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын Спортын ерөнхий газрын дэргэдэх Grand China Sports ТӨКомпанитай Монголын спортын холбоод Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурах арга хэмжээ боллоо.

Спортын холбоодоос 20 спортын холбоод энэхүү арга хэмжээнд байлцсан ба Монголын Уулчдын Үндэсний Холбоог төлөөлөн Дэд ерөнхийлөгч Б.Золжаргал Grand China Sports ТӨКомпанийг төлөөлөн ТУЗ-ийн дарга Хуй Дай Вэй нар уулын спорт, түүн дотроо Спорт авиралт, Пара авиралт дээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

Манай холбоо Хятадын Уулын Холбоотой хамтын ажиллагаагаа энэ сарын 28-аас 7-р сарын 4-ний хооронд хийгдэх 2 улсын залуучуудын шигшээ багуудын хамтарсан бэлтгэлээр эхэлж байгаа юм.



19. 6-р сарын 28 нд

Монголын Уулчдын Үндэсний Холбооны "Дөрвөн бэрх" цомны эхний эзэд МУГТ, ОУХМ Б.Гангаамаагийн нэрэмжит "Альпинад 2017" уулчдын цугларалт-авиралт дээр олгогдох гэж байна. Энэхүү цомны #1 дугаарыг МУГТ, ОУХМ Б.Гангаамаад олгоно.





20. 6-р сарын 28-с 7-р сарын 4

БНХАУ Бээжин хот: Хятадын уулын холбоотой урт хугацаанд хамтран ажиллах уулзалтын дагуу манай залуу тамирчид хоёр дасгалжуулагчийн хамт БНХАУ-н Спорт авиралтын залуучуудын шигшээ багтай хамтарсан бэлтгэл амжилттай хийв. МУҮХ төлөөлж 1 хүн, 2 дасгалжуулагчболон 6 тамирчин нийт 9 хүний бүрэлдхүүнтэй баг явсан



21. 7-р сарын 5-9



Сингапур улс: Олон улсын спорт авиралтын холбооноос зохион байгуулагддаг спорт авиралтын 2017 оны азийн залуучуудын аварга /AYCH-2017/ шалгаруулах тэмцээнд 2 тамирчин оролцуулсан

Үйл ажиллагааны тайлан



22. 7-р сарын 20 нд

"Снежный барс" буюу цасны барс хөтөлбөрийг эхлүүлэхээ албан ёсоор зарлаад байсан Завхан аймгийн "Уулсын оргил өөд" клубын уулчид ОУХМ Ө.Батманлай, С.Болор-Эрдэнэ нар Киргизийн Уулын Холбооноос зарласан Mountain Spirit 2017 хөтөлбөрт Монголын Уулчдын Үндэсний Холбооны нэрийн өмнөөс хамрагдан Таджикистан, Киргизстан улсын хил дээр орших Ленин оргилд (7,134 м) олон улсын экспедицэд багтан амжилттай авиралт хийлээ.



23. 7-р сарын 29 нд



Үйл ажиллагааны тайлан

Японы Уулын Холбооны (Japan Mountaineering Association) зөвлөх Тадао Канзаки, Японы Уулын Клуб (The Japanese Alpine Club)-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Акико Имада болон клубын бусад гишүүдийг Монгол улсад аялал хийх үеэр Монголын Уулчдын Үндэсний Холбоог төлөөлөн Дэд ерөнхийлөгч Б.Золжаргал уулзалт хийлээ.

Уулзалтаар Японы уулын клуб Монголын Уулчдын Үндэсний холбоо болон холбооны гишүүн клубуудтэй хамтран байгаль орчин, уулын орчныг цэвэр байлгах, япон хүүхдүүдийг байгалийн хаданд авиралт хийнгээ байгаль орчноо хамгаалах, хог цэвэрлэх чиглэлд хамтарсан кампанит ажил зохион байгуулах талаар санаачлага гаргасан бөгөөд хамтран ажиллах тал дээр санал солилцлоо

24. 8-р сарын 26-27

2017 оны Хаданд авиралтын улсын хотын аварга шалгаруулах тэмцээнийг МУҮХ, Уулын спортын олон улсын хэмжээний мастер Д.Чадраабал агсаны гэр бүл, садан төрөл, найз нөхөд хамтран Төв аймаг, Борнуур сумын нутагт байрлах “Дуган хад” байгалийн хаданд 2 өдрийн турш амжилттай зохион байгуулан өндөрлөлөө. Хаданд авиралтын Улсын аварга шаглгаруулах тэмцээнд зохион байгуулагчдийн 20 гишүүн, 12 багийн болон хувиараа оролцож байгаа тамирчид гэсэн нийт 93 тамирчид оролцлоо. Тэмцээнд оролцсон тамирчид маань 42 багц медалийн төлөө хурдны авиралт болон техникийн авиралтын хоёр төрлөөр бүтэн 2 өдрийн турш өрсөлдөж дүнгээ гаргалаа.



25. 10-р сарын 20-21



хүртлэх насны залуучуудын аварга шалгаруулах нээлттэй тэмцээнд оролцов.

26. 10-р сарын 30

Олон Улсын Уулын Холбоо (UIAA) болон Азийн Уулын Холбоо (UAAA)-ны Ерөнхий Ассамблей Иран улсын Шираз хотод зохион байгуулагдлаа.

Монголын Уулчдын Үндэсний Холбоо нь ОУУХолбооны бүрэн эрхэт гишүүн, АУХолбооны ажиглагч гишүүн бөгөөд хуралд Холбоог төлөөлж Ерөнхийлөгч Б.Тулга, Дэд ерөнхийлөгч Б.Золжаргал нар оролцлоо.

Хуралд Монголын Уулчдын Үндэсний Холбоо 2018 оны Ерөнхий Ассамблейг Монгол улсад зохион байгуулахтай холбоотойгоор холбооны үйл ажиллагааны тайлан, Ерөнхий ассамблейг хэрхэн зохион байгуулах тухай илтгэл тавилаа. Мөн дараах асуудлуудыг шийдүүллээ. Үүнд:

1. ОУУХолбооны сургалтын хороо (Training Standard Panel)-той Сургагч багш бэлтгэх, мөн өндөр уулын авиралтын замуудыг зэрэгэлэх 2 жилийн төслийг 2018 оноос хэрэгжүүлэх. Тухайн төслийн санхүүжилтийг Petzl Foundation-ээс гаргуулах асуудлыг шийдүүлсэн
2. Хятадын Уулын Холбоо (СМА)-ны дэмжлэгтэйгээр олон улсын стандартын тэмцээн зохион байгуулах стандартын Мөсөнд авиралтын байгууламж байгуулахаар болов.
3. Хятадын Уулын Холбоо (СМА)-ны дэмжлэгтэйгээр Спорт авиралтын хамтарсан бэлтгэлүүдийг уламжлал болгон тогтмолжуулах, жилд хамгийн багадаа 1 удаа тамирчдыг илгээхээр болов.



Үйл ажиллагааны тайлан

4. ОУУХолбооны Мөсөнд авиралтын хорооноос Монгол улсад Дэлхийн цомын тэмцээнийг зохион байгуулах хүсэлтийг тавьж Монголын УУлчдын Үндэсний Холбооноос БНСУ, БНХАУ-ын Дэлхийн цомын тэмцээнийг зохион байгуулах багт орж ажиллуулах, шүүгч зохион байгуулагчдыг хамтран бэлтгэхээр болов.

5. Непалын Уулын Холбоо (NMA), Олон улсын Уулын Хөтөчдийн Холбоо (IFMGA) нартай хамтран дотоодын хөтөчдийн сургалтын системийг бий болгох, сургалтанд хамрагдахаар тус тус боллоо.




27. 11-р сарын 3 нд

Улаанбаатар аялагч клуб-ын нэрэмжит Бага насны хүүхдүүдийн дундах Спорт авиралтын тэмцээн URSA Sport Club-т энэ жил 2 дахь жилдээ амжилттай зохион



байгуулагдасан. Энэхүү тэмцээнд оролцож буй бяцхан тамирчдын тоо өмнөх жилийнхээс ихэссэн байна

Үйл ажиллагааны тайлан



28. 11-р сарын 28 нд

Монголын Уулчдын
Үндэсний Холбооны
/МУҮХ/ Хяналтын
Зөвлөлийн гишүүн, ахмад
уулчин спортын мастер
Ш.Мөнхбаатар холбооны
байранд зочилон ирж
МУҮХ-ны үйл ажиллагаа,
2016 болон 2017 оны
хийгдсэн ажилд хяналт
хийн дүгнэлт
гаргалаа. Тэрээр МУҮХ-
ны хийсэн ажилд сэтгэл
хангалуун байгаагаа
илэрхийлэн, цаашдын
ажилд амжилт хүсээд
буцлаа.



29. 11-р сарын 25-28 нд



Үйл ажиллагааны тайлан

Холбооны Сургалт, аюулгүй ажиллагааны хороо [Wild Nature Sports](#) хамтран зохион байгуулсан Цасан нурангинаас урьдчилан сэргийлэх сургалтыг [Alaska Avalanche Specialists](#)-ийн үүсгэн байгуулагч, цасан нурангийг 35 жил судалж, сургалт, консалтинг хийдэг мэргэжилтэн Билл Глүүд урилгаар ирэн 2 өдөр сургалтыг явууллаа. 11-р сарын 26-ны Ням гаригт Холбооний гишүүн клубуудын 16 төлөөлөгчид, нэмэлтээр нээлттэй бүртгэсэн 16 хүн, нийт 32 хүнд Хээрийн дадлага сургуулилтыг орж байна





МОНГОЛЫН УУЛЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО 2018 ОНЫ ТАЙЛАН

1. 1-р сарын 7-9

БНХАУ, Бээжин хот: Мөсөнд авиралтын Дэлхийн цомын тэмцээнд 6 тамирчин оролцуулсан

Багийн бүрэлдэхүүнд:

1. Багийн ахлагч - МУҮХ-ны Дэд Ерөнхийлөгч Б.Золжаргал
2. Тамирчин – Воарлд саммит клубын тамирчин Н.Нялхбаяр
3. Тамирчин - Сутайн бор клубын тамирчин Н.Хэрлэн
4. Тамирчин - Сутайн бор клубын тамирчин О.Сайханжаргал
5. Тамирчин – Улаанбаатар аялагч клубын тамирчин Д.Отгонхүү
6. Тамирчин - Хязгааргүйд мац клубын тамирчин Д.Энхбаатар
7. Тамирчин - Хязгааргүйд мац клубын тамирчин Г.Хүрэлбаатар



2. 1-р сарын 27-28

“Ice Challenge-2017” Мөсөнд авиралтын улсын аварга шалгаруулах VI удаагийн тэмцээнийг зохион байгуулсан



3. 2-р сарын 11



Үйл ажиллагааны тайлан

Монгол улсаас оролцсон 7 тамирчин Мөсөнд авиралтын Дэлхийн цом, Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд маш амжилттай оролцож багийн дүнгээр 4-р байранд жагсаж

Мөсөнд авиралтын Ази тивийн аварга шалгахуулах тэмцээний Мөнгөн медалийн эзэн Сутайн бор клубын тамирчин Спортын дэд мастер Н.Хэрлэн, Хүрэл медалийн эзэн Хязгааргүйд мац клубын тамирчин Спортын мастер Д.Энхбаатар нар тус тус шалгарлаа.



4. 3-р сарын 22-24

ОХУ Улаан-Үүд хотын спорт авиралтын аврага шалгаруулах тэмцээнд дөрвөн тамирчин амжилттай оролцов.



5. 3-р сарын 21



Үйл ажиллагааны тайлан

МУБИС-ын Биеийн тамир спортын сургуультай дөрвөн жил хамтран ажиллах гэрээ байгуулав. Хамтын ажиллагааны хүрээнд спорт авиралтыг ханыг ашиглах, тэмцээн уралдаан зохион байгуулах, хамтарсан сургалт хийх.



6. 4-р сарын 24

Спорт авиралтын 2018 оны Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулав. 14 клубийн 60 тамирчин 24 багц медалын төлөө өрсөлдөв.



7. 5-р сарын 03



Үйл ажиллагааны тайлан

Спорт авиралтын 2018 оны Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулав. 15 клубийн 82 тамирчин 36 багц медалын төлөө өрсөлдөв.



8. 5-р сарын 29

Монголын Уулчдын Үндэсний холбоо болон БНХАУ-ын Уулын холбооны хамтын ажиллагааны хүрээнд 2018 оны 5-р сарын 09-10 нд БНХАУ-ын Нинг Бо хотод зохиогдох "Нэг Зам Нэг Бүс" 2018 оны цуврал 1 тэмцээнд 2 тамирчин амжилттай болов.



9. 7-р сарын 10-11




Монголын Уулчдын Үндэсний холбоо болон БНХАУ-ын Уулын холбооны хамтын ажиллагааны хүрээнд 2018 оны 7-р сарын 10-11 нд БНХАУ-ын Төвд , Лахас хотод "Нэг Зам Нэг Бүс" 2018 оны цуврал 2 тэмцээнд 2 тамирчин амжилттай болов.

Үйл ажиллагааны тайлан



10. 7-р сарын 24-ээс 8-р сарын 06

Спортын авиралтын залуу баг, тамирчид 7-р сарын 24-ээс 8-р сарын 05 нд ОХУ-ын Москва хотод ОХУ-ын залуу баг тамирчидтай хамтарсан бэлтгэл хийв.





11. 8-р сарын 6

2018 оны Хаданд авиралтын хотын шалгаруулах тэмцээнийг Нийслэлийн биеийн тамир спортын газартай хамтран Сөгнөрөгт 1 өдрийн турш амжилттай зохион байгуулсан. Тэмцээд нийт 12 багийн 48 тамирчин 24 багц медалын төлөө өрсөлөв.



12. 8-р сарын 08-09

ОХУ Москва хотод Спорт авиралтын залуучуудын дэлхийн аврага шалгаруулах тэмцээнд гурван тамирчин амжилттай оролцов.





13. 8-р сарын 17

2018 оны Хаданд авиралтын улсын аврага шалгаруулах тэмцээнийг Дуган хад амралтын газартай хамтран Дуган хаданд 2 өдрийн турш амжилттай зохион байгуулсан. Тэмцээд нийт 14 багийн 75 тамирчин 36 багц медалын төлөө өрсөлөв.



14. 08-р сарын 18-27

XVIII Азийн зуны спортын наадам энэ оны 8 дугаар сарын 18-наас эхлэн 9 дүгээр сарын 12-ны өдрүүдэд Индонез улсын Жакарта, Палембэн хотуудад зохион байгуулагдав. Спорт авиралтын төрөлд улсаа төлөөлөн гурван тамирчин амжилттай оролцов. Монголын уулчдыг төлөөлж Спорт авиралтын баг анх удаа оролцов.





15. 08-р сарын 20-26

Онцгой Байдлын Ерөнхий Газар, Монголын Уулчдын Үндэсний Холбоо хооронд 2018 онд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн дагуу өндөр уулын бүсэд авирах аюулгүй ажиллагаа, аврах ажиллагааны "Алтай Таван Богд-2018" сургалтыг Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг, Алтай Таван Богд ууланд зохион байгууллаа. Тус сургалтыг JCI хайкинг клуб хамтран зохион байгуулсан бөгөөд Оросын Холбооны Улсын Уулын холбооны салбар холбоо болох Буядын Уулын Холбооноос 3 сургагч багш уригдан оролцлоо. Энэхүү сургалт нь Онцгой Байдлын Ерөнхий Газар, Баруун бүсийн аймгуудын Онцгой Байдлын Газрууд буюу Баян-Өлгий аймаг, Ховд аймаг, Завхан аймаг, Говь-Алтай аймгийн удирдлагууд, аврагчид, мөн Зэвсэгт хүчний 341-р анги болон Уулын тусгай баталион 331-р ангийн байлдагч нарт тусгайлан зориулагдсан бөгөөд ОХУ-ын Онцгой Байдлын Газрын (МЧС России) Байкал орчмын эрэн хайх отряд, Буярд улсын эрэн хайх отрядын аврагч-сургагч, Спортын мастер уулчид ирсэн нь онцлог байлаа. Түүнчлэн, тус сургалтанд Монголын Уулчдын Үндэсний Холбооны гишүүн клубууд болох Хайрхан Аялагч Клуб, Улаанбаатар аялагч клуб, Хязгааргүйд Мац уулын спортын клуб, Тэнгэр уулчдын клуб, Мазаалай клуб, Саммит клуб, Хаан Банкны уулын клубээс тус тус 10 уулчин оролцов. Тус сургалтын хүрээнд Алтай Таван Богд уулын Малчин оргилд (д.т.д 4056 метр) 65 хүний бүрэлдэхүүнтэй, Хүйтний оргилд (д.т.д 4374 метр) 14 хүний бүрэлдэхүүнтэй тус тус авиралтыг аюул осолгүй, амжилттай зохион байгууллаа.

Энэхүү сургалтанд манай хүчний байгууллагуудын авран хамгаалах ажиллагааны аврагчдыг өргөн бүрэлдэхүүнтэй хамруулсан ба Монголын уулчин-аврагч, уулын цэргүүдийн чадавхийг сайжруулахад чухал үр дүнтэй болсон бөгөөд цаашид энэхүү чиглэлийн сургалтыг үе шатлалтай үргэжлүүлэх эхлэл болсон.

Мөн түүнчлэн монголын уулын спортын түүхэнд манай улс Оросын Холбооны Улсын Уулын холбоотой дахин харилцаагаа сэргээж түүний салбар холбоо болох Буярд улсын Уулын Холбоотой "Хамтын Ажиллагааны Санамж Бичиг"-т гарын үсэг зурсан нь хамтын ажиллагаагаа бэхжүүлсэн түүхэн үйл явдал боллоо.





16. 8-р сарын 28

Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг Алтай Таван Богд уулын Үндсэн отог дээрх үүсээд байсан хур хогийг Монголын Уулчдын Үндэсний Холбоо болон Онцгой Байдлын Ерөнхий Газартай хамтран хийсэн уулын авиралт болон аврах ажиллагааны сургалтын дараа нэгдсэн байдлаар Баян-Өлгий аймгийн Онцгой Байдлын Газар, Цэнгэл сумын ЗДТГ, Монголын Уулчдын Үндэсний Холбоо хамтран ачиж цэвэрлэлээ.

Алтай Таван Богд уулын үндсэн отог дээрх хогны менежментийн асуудлаар цаашид Монголын Уулчдын Үндэсний Холбоо нь Байгаль Орчин, Аялал жуулчлалын яам, Тусгай Хамгаалалттай Газар нутгийн захиргаатай хамтран хэрхэн шийдэх тал дээр харилцан санал солилцож байгаа бөгөөд тодорхой шийдэлд хүрнэ гэдэгт найдаж байна.

Зохион байгуулалтыг хариуцаж гүйцэтгэсэн Баян-Өлгий аймгийн Онцгой Байдлын Газар, Цэнгэл сумын ЗДТГ Газар, Гавьяат тамирчин, ОУХМ Б.Гангаамаад талархал илэрхийлье.



17. 9-р сарын 13-27

Монголын Уулчдын Үндэсний Холбоо БНХАУ-ын Уулын холбооны хамтын ажиллагааны хүрээнд Спорт авиралтын баг тамирчид БНХАУ-ын шигшээ багийн бэлтгэлийн баазад хамтарсан бэлтгэл хийв.





18. 10-р сарын 04-08 нд

Олон улсын уулын холбоо UIAA ны 2018 оны Ерөнхий Ассамблей Монгол Улсад 2018.10.04-08 ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж дууссан.



19. 10-р сарын 7-9 нд

Монголын Уулчдын Үндэсний холбоо болон БНХАУ-ын Уулын холбоотой Спорт авиралтын хамтын ажиллагааны хүрээнд 2018 оны 10-р сарын 09-10 нд БНХАУ-ын Хуай Ан хотод зохиогдох "International Climbing Elite Tournament 3" тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцов.





20. 11-р сарын 19 нд

Бага насны хүүхдүүдийн дунд зохиогддог Хүн Аалз спорт авиралтын III тэмцээн амжилттай болж өндөрлөө. Нийт 39 бяцхан тамирчид өрсөлдсөнөөс Эрдэнэт болон Өмнөговь аймгаас тамирчид ирж оролцлоо.



21. 11-р сарын 21 нд

Дэлхийн Уулын холбоо /UIAA/ болон Оросын Уулын Холбоо /RMF/ хамтран ОХУ-н Киров хотод залуу тамирчидад зориулсан дэлхийн цом болох хананд бэлтгэл, сургуулалт жил бүр зохион байгуулладаг. Манай баг тамирчид ОХУ-ын баг тамирчидтай 14 өдрийн хамтарсан бэлтгэл амжилттай хийв.





22. 12-р сарын 15-16 нд

Олон Улсын Уулын Холбоо/UIAA/-ноос анх удаа мөсөнд авиралтын дэлхийн хосолсон төрлийн/combined/ аварга шалгаруулах тэмцээнийг ОХУ-ын нийслэл Москва хотод зохион байгуулав. Манай хоёр тамирчин амжилттай оролцов.



23. 12-р сарын 15 нд

МУҮХ-ны Цол зэргийн комисс хуралдаж цол, зэрэг хүссэн 16 материал ирүүлсэнийг зохих журмын дагуу хэлэлцлээ.

Спорт авиралтын төрөлд
Гуравдугаар зэрэг 1
Нэгдүгээр зэрэг -1
Дэд мастер-1
Өндөр уулын авиралтын төрөлд
Гуравдугаар зэрэг 8
Хоёрдугаар зэрэг 3
Нэгдүгээр зэрэг 1
Дэд мастер 1 Тус тус баталлаа



24. АЛТАН АЛХ ШАГНАЛ ГАРДУУЛАХ ЁСЛОЛ 2018

Монголын Уулчдын Үндэсний Холбооноос зохион байгуулдаг GOLDEN ICE AXE AWARDS 2018 ёслол хүндэтгэлийн арга хэмжээ сайхан болж өндөрлөлөө. Нийт 8 номинацад 7 клубын 31 тамирчид өрсөлдсөн ба уулын спорт сонирхогчид болон мэргэжлийн тамирчдын сүүлийн 3 жилийн амжилтыг үндэслэн шилдгүүдийг тодрууллаа.



25. ШИЛДЭГ МЕНЕЖМЕНТТЭЙ СПОРТЫН ХОЛБОО

Монголын Уулчдын Үндэсний Холбоо Монголын Үндэсний Олимпийн Хорооны спортын салбарын "Бөртэ Чоно" шагнал гардуулах арга хэмжээнээс 2018 оны "Шилдэг Менежменттэй Спортын Холбоо" шагналаар шалгарлаа. Холбооны 2016 онд сонгогдсон Удирдах зөвлөлийн өргөтгөсөн Менежментийн багт 50 гаруй уулын спорт, менежмент, бизнес болон бусад салбарын олон шилдэг мэргэжилтэн, менежерүүд сайн дураар нэгдсэн нэг зорилгын дор зангидагдан уулын спортын хөгжилд өндөр хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Бидний 2018 онд зохион байгуулсан

- Олон Улсын Уулчдын Холбоо (UIAA), Азийн Уулчдын Холбоо (UAAA)-ын Ерөнхий Ассамблейг Монгол улсад өндөр хэмжээнд зохион байгуулсан,
- Олон Улсын Уулчдын Холбооны уулын спортын аюулгүй ажиллагааны гарын авлагыг Монгол хэлэнд орчуулсан,
- 2018 оны 1 дүгээр сард БНСУ-ын Чеонсонг хотод зохион байгуулагдсан Мөсөнд авиралтын Дэлхийн цомын тэмцээнээс Монгол тамирчин анх удаа Мөнгө, хүрэл медаль хүртсэн,



Үйл ажиллагааны тайлан

- Спорт авиралтын шигшээ багийн БНХАУ-ын Уулын Холбооны дэмжлэгтэйгээр Хятадын санхүүжилтээр 6 удаа хамтарсан бэлтгэл хийлгэж, Спорт авиралтын цуврал тэмцээнд оролцуулсан,
- Уулын спортын датабаазыг нэвтрүүлсэн,
- Ууланд авирах, аялах журмыг БОАЖЯ-тай хамтран боловсруулж гаргасан,
- ОБЕГ-ын 50 уулчин аврагчийг бэлтгэж эхэлсэн,
- Уулын спортын сургалтын төвийг байгуулсан,
- Алтай Таван Богд уулын авиралтын замуудыг гаргаж газрын зураг, маршрутжуулсан зэрэг томоохон ажил, төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хийж гүйцэтгэснийг үнэлсэн шагнал байлаа.





МОНГОЛЫН УУЛЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО 2019 ОНЫ ТАЙЛАН

1. 1-р сарын 06 нд

Монголын уулчдын үндэсний холбооны менежментийн багийн нэгдсэн аялал авиралтыг зохион байгуулсан ба уг авиралтанд нийт 14 хүний бүрэлдхүүнтэй Хан Хэнтий нурууны ноён орогил “Асралт Хайрхан” дтд 2799 метрт амжилттай авирсан. Авиралтанд Монголын уулчдын үндэсний холбооны Ерөнхийлөгч Б.Тулга болон Удирдах зөвлөлийн гишүүд оролцон юм.



1. 1-р сарын 12-13 нд

Монгол Улсын мөсөнд авиралтын шигшээ баг БНСУ-ын Чонсон хотод 1-р сарын 12-13 нд болох Дэлхийн цомын 2019 оны цуврал тэмцэнд монгол улсаа төлөөлж Багийн бүрэлдэхүүнд:

1. Багийн ахлагч - МУҮХ-ны Өндөр уулын хорооны гишүүн Ж.Оюунцэцэг
2. ОУ шүүгч - МУҮХ-ны Мөсөнд авиралтын хорооны гишүүн С.Дэлгэрмөрөн
3. Тамирчин - Сутайн бор клубын тамирчин Н.Хэрлэн
4. Тамирчин - Сутайн бор клубын тамирчин О.Сайханжаргал
5. Тамирчин - Сутайн бор клубын тамирчин Б.Ариунбаяр
6. Тамирчин - Хязгааргүйд мац клубын тамирчин Д.Энхбаатар
7. Тамирчин - Хязгааргүйд мац клубын тамирчин Г.Хүрэлбаатар
8. Тамирчин - Хайрхан аялагч клубын тамирчин С.Энх-Оюун
9. Тамирчин- Урса спорт бэлтгэлийн төвийн тамирчин Н.Анужин нар оролцсон



Энэхүү тэмцээнд Монголын 7 тамирчин хурд, техникийн төрөлд өрсөлдөх бөгөөд нийт 18 орны 102 тамирчин оролцосон. МУУХ-ны гишүүн С.Дэлгэрмөрөн аспирант шүүгчээр ажилласан нь энэ удаагийн багийн бүрэлдэхүүний нэг онцлог байлаа.



2. 1-р сарын 18-20

Монгол Улсын мөсөнд авиралтын шигшээ баг БНХАУ -ын Бээжин хотод 1-р сарын 18-20 нд болох Дэлхийн цомын 2019 оны цуврал тэмцээнүүдийн хоёрдугаар тэмцээн. Багийн ахлагч - МУУХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн, Дэд ерөнхийлөгч С.Алдархишиг

Тамирчин - Сутайн бор клубын тамирчин ОУ- хэмжээний мастер Н.Хэрлэн

Тамирчин - Сутайн бор клубын тамирчин Спортын мастер О.Сайханжаргал

Тамирчин Улаанбаатар аялагч клубын тамирчин Спортын дэд мастер Д.Отгонхүү

Тамирчин - Сутайн бор клубын тамирчин Ж.Сэдэд .Тамирчин - Хязгааргүйд мац клубын тамирчин Б.Баярмаа

Тамирчин - Хайрхан аялагч клубын тамирчин Спортын мастер Б.Дэнсмаа

Тамирчин - Сутайн бор клубын тамирчин Б.Ариунбаяр



Үйл ажиллагааны тайлан



3. 1-р сарын 24 нд

Монголын Уулчдын Үндэсний Холбооноос зохион байгуулсан Мөсөнд авиралтын үндэсний шүүгч бэлтгэх онол практик хосолсон сертификаттай сургалтын нэгдүгээр шатны сургалт амжилттай болж өндөрллөө. Сургалтыг Монголын Уулчдын Үндэсний Холбооны шүүгчдийн зөвлөлийн дарга ОУ-ын шүүгч Дэлгэрмөрөн удирдан явуулсан.



4. 1-р сарын 26-27

ICE CHALLENGE-2019 Мөсөнд авиралтын улсын аварга шалгаруулах тэмцээн Найрамдал зусланд 2019 оны 1-р сарын 26-27 ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Энэ удаагийн тэмцээнд 12 багийн 44 тамирчин хурд хүчээ үзсэн ба мөн ОХУ-ын Эрхүү мужаас 3 тамирчин оролцосон.





5. 2-р сарын 9нд

Мөсөнд авиралтын Дэлхийн цомын 5 дахь цуврал БНФУ-ын Шампани ан Ванойз хотноо болсон уг тэмцээнд тус холбооны мөсөнд авиралтын хорооны дарга Ж.Оюунцэцэг, “Сутайн бор” клубын тамирчин Спортын мастер О.Сайханжаргал нар оролцов.



6. 2-р сарын 16нд

Монголын уулчдын үндэсний холбооны сургалт, аюулгүй байдлын үйл ажиллагаа өргөжиж, олон улсын түвшний сургалтын стандартыг Монгол улсад нэвтрүүлэх, мэргэжлийн уулчин, уулын хөтөч сурган бэлтгэх боломж гадаад харилцааны хамтын ажиллагааны үр дүнд бий болж байна.

Манай холбооны дэргэдэх “Алтитуд” сургалтын төв нь Непалын уулын холбоотой сургалтын тал дээр хамтран ажиллах, 1+1 хөтөлбөр буюу Монгол улсад өндөр уулын анхан шатны сургалтыг мэргэжлийн сургагч багш урин явуулан, үргэлжлүүлээд Непал улсад ахисан түвшний болон мэргэжлийн уулын хөтөч бэлтгэх олон улсын IFMGA стандартын сургалтанд суралцуулах зэрэг талаар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.





7. 2-р сарын 18 нд

Монголын Уулчдын Үндэсний Холбооны гишүүн клуб болох Саммит клубын урилгаар БНСУ-ын Korean Alpine Club-ын техник, аюулгүй байдлын мэргэжилтэн Mr.OM, Mr.Young нар хүрэлцэн ирж ирэх зун монгол улсад авиралт хийх уулын зам, нөхцөл байдлыг судлахын зэрэгцээ Холбооны Удирдах Зөвлөлийн гишүүдтэй уулзаж цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар ярилцан санал бодлоо солилцлоо.



8. 2-р сарын 24 нд

Олон Улсын Уулчдын Холбоо/UIAA/-ны мөсөнд авиралтын дэлхийн цомын аварга шалгаруулах VI цуврал буюу энэ оны отгон цуврал АНУ-ын Колорадо муж, Денвер хотод 2019 оны 2 дугаар сарын 22-ноос 24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан.

Монголын Уулчдын Үндэсний Холбоог төлөөлж Говь-Алтай аймаг, Тонхил сум, Уулын спортын ууган мастер Я.Жанцангийн нэрэмжит “СУТАЙН БОР” клубын тамирчин, Мөсөнд авиралтын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний мөнгөн медальт, Монгол улсын хошой аварга, ОУХМ Н.Хэрлэн оролцсон байна. ОУУХ/UIAA/-ны мөсөнд авиралтын ДЦАШТ-ий хурдны төрөлд оролцсон МУУХ, “СУТАЙН БОР” клубын тамирчин, ОУХМ Н.Хэрлэн урьдчилсан шатанд V байр эзэлж гараагаа маш амжилттай эхлүүлж хагас шигшээд шалгарсан. Хагас шигшээ шатны эхний гараанд 11.85 секундээр бариалсан боловч шүүгчид “хананаас салсан” гэж үзсэн бололтой. Улмаар XI дүгээр байр эзлэн тэмцээнээ өндөрлүүллээ.





9. 3-р сарын 07нд

Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Олон улсын Олимпийн Хорооны Спорт ба Эмэгтэйчүүд коммисоос зохион байгуулсан "Олимп, спортод эмэгтэйчүүдийн оролцоо" сэдвээр Монголын Уулчдын Үндэсний Холбооны эмэгтэй менежерүүд, Монголын буудлагын холбоотой хамтран туршлага судлах уулзалтыг 2019.03.07-ны өдөр зохион байгууллаа.

Мэргэжлийн бус эмэгтэй менежерүүд спортын хөгжилд хэрхэн хувь нэмэр оруулж буй талаар:

Түүний ач холбогдол болоод ашиг сонирхолгүйгээр хэрхэн авч явах, Сайн дурын үндсэн дээр ажил хэрхэн ахицтай байгаа талаар, Өндөр зохион байгуулалт, Нарийн мэдрэмжийг мэдрүүлж зангидаж чадвал залуу үеийн хүмүүжилд хэрхэн нөлөөлж болох талаар нээлттэй хэлэлцэж санал бодол туршлага харамгүй ярилцсан сайхан арга хэмжээ болло.





10. 3-р сарын 8-10

ОУУХ/UIAA/-ны Мөсөнд авиралтын 2019 оны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн ОХУ-ын Киров хотод 3 дугаар сарын 8-наас 10-ны өдрүүдэд зохион байгуулагдав. ОУУХ-ны Мөсөнд авиралтын 2018-2019 оны улирлын отгон тэмцээн юм. Монголын Уулчдын Үндэсний Холбооны багийн бүрэлдэхүүнд “Сутайн бор” клубын тамирчин ОУХМ Н.Хэрлэн, Спортын мастер О.Сайханжаргал Улаанбаатар аялагч клубын тамирчин Ч.Манхдахбаяр нар оролцсон. Энэ оны хамгийн том, шувтаргын тэмцээнд дэлхийн 18 орны нийт 70 гаруй тамирчид хурд хүч,авхаалж самбаагаа соринсон байна.



11. 3-р сарын 8-10



Эрхүү хотын аварга 2019.03.08-наас 10-ны хооронд ОХУ-ын Кировын тэмцээнтэй зэрэгцээд ОХУ-ын Эрхүү хотод Эрхүүгийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцов. Уг тэмцээнд Монгол улсаа төлөөлөн Монголын уулчдын үндэсний холбооны тамирчин Д.Отгонхүү хурдны төрөлд өрсөлдөж 10:06 секундын амжилт үзүүлж 2- байр Мөнгөн медалийн эзэн болов.



12. 3-р сарын 09

Олон улсын уулчдын холбооны Залуучуудын комиссын ээлжит хуралдаан Киприйн Ларнака хотноо болов. Хуралдааныг Киприйн уулчдын холбооноос эрхлэн зохион байгуулав. Энэ удаагийн хурлыг шинээр сонгогдсон ОУУХ-ны Залуучуудын комиссын Ерөнхийлөгч Марк Денисон удирдан явуулав. ОУУХ-ны Залуучуудын комиссын гишүүн



О.Батсайхан нь Skype-ээр холбогдож хуралдаанд оролцож санал бодлоо хэлэв. Тухайлбал, тэрээр ОУУХ-ны Залуучуудын комиссын Ерөнхийлөгч болон хуралдаанд оролцож буй гишүүдэд МУҮХ-ны нэрийн өмнөөс баяр хүргэж амжилт хүсэхийн зэрэгцээ МУҮХ-ноос 2018 онд зохион явуулсан үйл ажиллагааны талаар товч танилцуулав.

13. 3-р сарын 10

Монголын Уулчдын Үндэсний Холбооны Сургалт, аюулгүй ажиллагааны хорооны дэргэдэх Алтитуд уулын сургуулийн 2019 оны төлөвлөгөөт сургалт "Олсны зангилаа" сэдвээр Холбооны гишүүн болон гишүүн бус сонирхсон байгууллага, хувь хүмүүст хүрлээ.



14. 3-р сарын 16

Монголын Уулчдын Үндэсний Холбооны Сургалт, аюулгүй ажиллагааны хорооны дэргэдэх Алтитуд уулын сургууль "Олсны зангилаа" сэдвээр хоёрдахь сургалт холбооны гишүүн клуб болон гишүүн бус сонирхсон байгууллага, хувь хүмүүст хүрлээ.



15. 3-р сарын 16

Монголын Уулчдын Үндэсний Холбооны Менежментийн багийн ээлжит уулзалт боллоо. Уулзалтанд шинэ болон хуучин гишүүд хооронд танилцан нээлттэй ярилцахын зэрэгцээ, Монголын уулчдын үндэсний холбооны 2016-2020 оны Стратеги төлөвлөгөөний биелэлтийг танилцууллаа. Мөн уулзалтанд маань сүүлийн үед олны анхаарлыг ихэд татаж буй Д.Энхтүвшин шарк хүрэлцэн ирж манай залууст өөрийн амьдралдаа хэрэгжүүлж, баримталж буй зарчим, туршлагаасаа хуваалцаж ярилцлаа.





16. 3-р сарын 29

Монголын Үндэсний Олимпийн Хороо/МҮОХ/-ны гишүүдийн хуралд Монголын Уулчдын Үндэсний Холбоо/МУҮХ/-г төлөөлж МУҮХ-ны Хүндэт ерөнхийлөгч бөгөөд зөвлөх, ОУХМ, МҮОХ-ны Хяналтын зөвлөлийн дарга Ж.Баянцагаан, МУҮХ-ны Дэд ерөнхийлөгч Б.Золжаргал, МУҮХ-ны Удирдах зөвлөлийн гишүүн, МҮОХ-ны Санхүүгийн хорооны гишүүн, доктор А.Батсүх нар оролцов.



17. 4-р сарын 01

Монголын Уулчдын Үндэсний Холбоо/МУҮХ/-ны урилгаар зочилж буй ахмад уулчин С.Галсан гуайд хүндэтгэл үзүүлэх уулзалт боллоо.

МУҮХ-ны байранд хүндэт зочныг МУҮХ-ны Хүндэт ерөнхийлөгч бөгөөд зөвлөх, ОУХМ Ж.Баянцагаан, МУҮХ-ны Ахмадын зөвлөлийн дарга, ОУХМ Д.Чагнаа, Удирдах зөвлөлийн гишүүн Л.Бүрэнтөгс, А.Батсүх, МУҮХ-ны Ажлын албаны дарга А.Удаанжаргал, МУГТ Г.Өсөхбаяр, МУГТ Б.Цэвээндаш, Олон Улсын Уулчдын Холбоо/UIAA/-ны Залуучуудын комиссын гишүүн О.Батсайхан, "Сутайн бор" клубын уулчид, Х.Батсайхан, Д.Хандсүрэн нар хүлээн авч уулзан хүндэтгэл үзүүлэв.





18. 4-р сарын 02

2019 оныг "Уулын аюулгүй ажиллагааны жил" болгон зарлалаа. Сүүлийн жилүүдэд уулын спорт нь бүх нийтийн сонирхлыг ихээхэн татаж, эх орны өнцөг булан бүрт уулын спортыг сонирхогчдын тоо эрс нэмэгдэж, эрчимжиж ирлээ. Энэ байдлыг анхааралдаа аван Монголын Уулчдын Үндэсний Холбоо 2019 оныг Уулын аюулгүй ажиллагааны жил болгон зарлаж тус ажлын хүрээнд Холбооны Сургалт, аюулгүй ажиллагааны хорооны дэргэдэх Алтитуд уулын сургуультай хамтран олон улсын болон дотоодын цуврал сургалтуудыг төлөвлөв.

19. 4 сарын 08

Монголын Уулчдын Үндэсний Холбооны Өндөр уулын авиралтын хорооноос зохион байгуулсан GPS ашиглах анхан шатны сургалт амжилттай зохион байгуулагдлаа. Энэ удаагийн сургалтыг Монголын Уулчдын Үндэсний Холбооны өндөр уулын авиралт, хайкинг хариуцсан Дэд ерөнхийлөгч С.Алдархишиг удирдсан ба сургалтанд нийт 9 клубын төлөөлөл оролцсон байна.



20. 4-р сарын 13

Өндрийн өвчин, цасны сохрол, хөлдөлт осголт, бэртэл, хугарал, цус алдалт, амьсгалын замын гэмтлийн үед үзүүлэх анхны тусламжийн хичээлийн эхний хэсэг амжилттай явагдлаа. Энэ удаагийн сургалтыг Монголын Уулчдын Үндэсний Холбооны эрүүл мэндийн хорооны дарга, гэмтэл согогс үндэсний төвийн эмч С.Мөнхдөл удирдсан.





21. 4 сарын 14

Монголын Уулчдын Үндэсний Холбооны календарьчлагдсан төлөвлөгөөний дагуу хийгддэг Спорт авиралтын Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 04-р сарын 14-ны өдөр амжилттай зохион байгуулагдлаа. Нийт 9 клубын 60 тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорьсон сайхан тэмцээн боллоо.



22. 4 сарын 20

Саммит клуб, Монголын Уулын Үндэсний Холбоотой хамтран зохион байгуулсан ДУГАН ХАД 2019 40 км-ийн уртын алхалт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Энэ жилийн алхалтанд оролцогчоор нийтдээ 2 холбоо, 13 клуб, 2 аж ахуйн нэгж оролцсон.





23. 5 сарын 09

Үйл ажиллагааны тайлан



Монголын Уулчдын Үндэсний холбоо болон БНХАУ-ын Уулын холбооны хамтын ажиллагааны хүрээнд 2019 оны 5-р сарын 11-12 нд БНХАУ-ын Нинг Бо хотод зохиогдох "Нэг Зам Нэг Бүс" 2019 оны цуврал 1 тэмцээнд манай улсаа төлөөлөн Хязгааргүйд мац клубын тамирчин Ц.Анар, "Улаанбаатар Аялагч" клубын тамирчин Ч. Мандахбаяр, нар ороцсон юм.

24. 5 сарын 18-19

Спорт авиралтын Улсын аварга шалгаруулах тэмцээн 2019 Нийт 10 багийн 86 тамирчид оролцсон байна.





25. 6 сарын 11-13

Монголын Уулчдын Үндэсний холбооноос Уулчдын нэгдсэн цугларалт “Альпиниад-2019” арга хэмжээг 2019 оны 6-р сарын 11-13 -ны өдрүүдэд Увс аймгийн Тариалан сумын нутаг Хархираа Түргэний уулсын Мөст хайрханд амжилттай зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд 17 клуб, 150 гаруй хүн оролцож

- Скайраннингийн тэмцээн
- Техникийн авиралт
- Чөлөөт авиралт гэсэн төрлүүдээр авиралт хийв.

Чөлөөт авиралт

Далайн түвшнээс дээш 4037 метрт орших оргилд чөлөөт авиралтаар 117 хүн амжилттай авиралт хийв.



Монголын Уулчдын Үндэсний Холбоо нь Увс аймгийн Тариалан сумын хүүхэд багачуудад зориулан номын хандив сайн санааны аяны уриалгыг клубууд, уулчид, аялагчдын дунд гарган, ном цуглуулж, хүлээлгэн өглөө. Нийт 4-н хайрцаг буюу 200 гаруй ном хүлээлгэн өгсөн байна.




Байгаль хамгаалах "Ногоон Паспорт" аянд Монголын уулчид нэгдэж, энэхүү арга хэмжээний үеэр гишүүд, оролцогчдод танилцуулав. "Ногоон Паспорт" нь Байгаль хамгаалах үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих, иргэдэд зөв дадал хэвшил олгох, байгаль орчноо хайрлан хамгаалах үйлсэд хүүхэд залуусыг уриалан дуудахад орших бөгөөд 12 хуудастай ба хуудас бүр нь ус, хог хаягдал, ногоон орчин, зохистой хэрэглээ, байгаль хамгаалах уламжлалт ёс заншил зэрэг чиглэлээр 12 ажлыг тусгасан.



26. 7 –р сарын 1-25

Монголын Уулчдын Үндэсний холбоо болон БНХАУ-ын Уулын холбооны хамтын ажиллагааны хүрээнд Спорт авиралтын олон улсын стандарт хана барих төслийн 2 дахь удаагийн уулзалт амжилттай болсон. Энэхүү уулзалтын хүрээнд Спорт авиралтын ханы 50 сая төгрөгний өртөг бүхий барилгын зураг хийлгэсэн.





27. 7 сарын 4-13

МУҮХ-ны Сургалт, аюулгүй ажиллагааны хороо нь Америкийн уулын хөтөчдийн холбооны хаданд авиралтын хөтөч, мөсөнд авиралтын зааварлагч багш Nathan Pooler болон Аляска мужийн Анкорей хотын их сургуулийн хаданд авиралтын зааварлагч багш Regan Marin нарыг урин, Батсүмбэрт 4 хоногийн хад болон өндөр уулын авиралт, аврах ажиллагааны сургалтыг Алтитуд төвийн багш нартай хамтран амжилттай зохион байгууллаа. Энэхүү сургалтад Улаанбаатар аялагч, Хамтдаа алхацгаая, Хоризон клубуудын гишүүд хамрагдаж, богино хугацаанд өргөн хүрээний мэдлэг, ур чадварт суралцан, дадлага хийж, хад болон өндөр уулын авиралтын явцад тохиолддог аюул, бэрхшээлийг хэрхэн урьдчилан харах, аюулгүй авирах талаар асууж, тодруулан, багш нарын туршлагаас сонсож, хэлэлцэж ярилцлаа.

Хаданд авирах

- Олсны 20-д төрлийн зангилаа
- Олс эвхэх 3 төрлийн арга техник
- Олс, дээс ашиглан анкор (бэхэлгээ) хийх 7 төрлийн арга техник
- Гацаа ашиглан бэхэлгээ хийх аргачлал
- Төмөр болон оёмол тоног хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгах
- Хаданд авирах техник
- Дээрээ бэхэлгээт авиралтад ашиглах тоног хэрэгсэл, авиралтын системийг угсрах болон ажиллагааг шалгах
- Хаданд авиралтын өмнө авирагч, хамгаалагч 2 хэрхэн нэг нэгнээ шалгах
- Хамгаалагч хийх 2 төрлийн арга техник, ашиглах тоног хэрэгсэл
- Хаднаас буух техник, ашиглах тоног хэрэгсэл
- Хувийн бэхэлгээний тоног хэрэгсэл, системийг хэрхэн угсрах, шалгах
- Авирах явцад ашигласан тоног хэрэгслийг хураан буулгах
- Хурдны авиралтын үед хэрхэн хамгаалах, хамгаалагч нарыг хэрхэн хянах
- Хурдны тэмцээний үеэр аюулгүй байдлыг хангах ажиллагаа
- Авиралтын үед авирагч болон хамгаалагч хэрхэн харилцаж ойлголцох, олон улсад ашиглаж тогтсон үг хэллэг
- Авиралтын аюулгүй байдлыг хангахад анхаарах зүйлс



Өндөр ууланд авирах

- Олсонд орох аргачлал, тухайн нөхцөл байдлаас хамааран авирагч хоорондын зайг тодорхойлох

- Өндөр уулын авиралтад олс тавих, тавьсан олсоор хэрхэн явах

- Өндөр уулын авиралтад дундын бэхэлгээ (цас, мөсний шруп, цасны гадас, хад, мод ашиглан) хийх, түүгээр хэрхэн явж өнгөрөх

Алтитуд төвийн багш нар өртөөлөн авирах, аврах ажиллагаа чиглэлээр суралцлаа:

- Хаданд гацаа байрлуулан өртөөлөн авирах

- Бэхэлгээний цэг сонгох, бат бэх бэхэлгээ хийх

- Бэхэлгээний олс хэрхэн тавих

- Хадны хадаас хадах, бэхэлгээний цэг болгон ашиглах

- Осолдогчид хэрхэн хүрэх, олсонд анхны тусламж үзүүлэх, газар буулгах

- Гэмтлийн улмаас буух боломжгүй осолдогчиг авч буух техник.

Мөн Аляска мужын Уулын Холбоо болон Монголын Уулчдын Үндэсний Холбоод хоорондын хамтын ажиллагааг эхлүүлэхээр ярилцаж тохиролцлоо.



28. 7 сарын 08

Монголын Уулчдын Үндэсний Холбооны Хүндэт ерөнхийлөгч, Монголын Үндэсний Олимпийн хорооны Хяналтын зөвлөлийн дарга Ж.Баянцагаан уулын спортын Гавьяат дасгалжуулагч цолоор шагнагдаж уулын спортынхон нэгэн гавьяатаар бүл нэмлээ. Ж.Баянцагаан уулын спортод анх 1958 оноос эхлэн өөрийн хүч, хөдөлмөрийг зориулж Монголын Уулчдын Үндэсний Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргаар 30 жил ажилласан билээ. Хүндэт ерөнхийлөгч, ахмад уулчин Ж.Баянцагааныг Монголын Уулчдын Үндэсний Холбооны Ерөнхийлөгч Б.Тулга болон Удирдах зөвлөл, ахмад уулчид Холбооны төв байранд хүлээн авч баяр хүргэж, хүндэтгэл үзүүллээ






29. 8 сарын 28-29

Монголын Уулчдын Үндэсний Холбоо болон Саммит уулын спортын клуб, БНСУ-ын Corean Alpine Club нарын хамтын ажиллагааны хүрээнд Corean Alpine Club-ийн 12 аймгийн салбар клубуудээс 29 аялагч Монголд 8-р сарын 24-29-ний хооронд айлчиллаа.



30. 8-р сарын 29- 9.03

Азийн Уулын Холбоо болон Казакстан улсын уулын болон спорт авиралтын холбооны зохион байгуулж буй Олон улсын хаданд авиралтын фестивалд монголын уулчдын үндэсний холбоог төлөөлөн Дэд Ерөнхийлөгч Б.Золжаргал, Санхүү хөрөнгө оруулалт хариуцсан захирал Н.Дөл-Эрдэнэ нар оролцоод ирлээ.



30. 9-р сарын 6-13

Олон Улсын Уулын Холбоо, Петцл сан, Монголын Уулчдын Үндэсний Холбооны хамтарсан сургагч багш бэлтгэх 3 жилийн хөтөлбөрийн эхний шатны уулын алхалт, авиралтад баг ахлах, хөтөч хийх болон зааварлагч, сургагч багш болоход шаардагдах суурь мэдлэг, ур чадвар олгох эхний шатны сургалтыг дараахь чиглэлээр амжилттай зохион байгууллаа.



СУРГАЛТЫГ

1. Стив Лонг, Их Британи улсын иргэн, Олон Улсын Уулын Холбооны Сургалтын хорооны дарга, сургагч багш, Олон улсын уулын хөтөч, 1978 оноос хойш олон улсад сургагч багш нарыг бэлтгэж байгаа туршлагатай (UIAA Head of Training Standard Panel, Instructor, IFMGA guide)
2. Андрэа Андрэу, Кипр улсын иргэн, Олон Улсын Уулын Холборны сургалтын хорооны гишүүн, сургагч багш, Америкийн уулын хөтөч, хаданд авиралтын хөтөч, 500 гаруй хадны зам тавьсан, 300 гаруй уулын авиралт хийсэн туршлагатай (UIAA Training Standard Panel member, Instructor, AMGA guide) тус тус сургалт хийлээ.



Сургалтанд УБ Аялагч клуб, Хайрхан аялагч клуб, Жаргалант клуб, Монголиан Маунтиан Саммит ХХК, Монголиа Экспедишнс ХХК, ОБЕГ, Монголын Уулчдын Үндэсний Холбооноос тус тус 11 хүн оролцов.

Сургалтыг дараахь чиглэлээр амжилттай зохион байгууллаа.

- Алхалт, авиралт, аялал төлөвлөх, зохион байгуулах, баг ахлах, багийн сэтгэл зүй
- Алхалтын техник (огцом налуу, халтиргаатай, сул хад чулуутай газраар хэрхэн алхах)
- Хувцас, хэрэгсэл (хувийн болон багийн хувцас, аяллын хэрэгсэл, хүнс төлөвлөх)
- Уулын цаг агаар (цаг агаарын мэдээ унших, үүл, салхины байдлаар шинжих)
- Зүг чиг олох (газрын зураг, луужин ашиглах, алхалтын хурд, хугацааг төлөвлөх, үзэгдэх орчин хязгаарлагдмал үед зүг чиг олох)
- Байгаль орчны мэдлэг (хүний байгаль орчинд үзүүлэх нөлөө, ул мөр үлдээхгүй аялах тэргүүн туршлага)



- Аюулыг илрүүлэх, эрсдлийг удирдах, аврах ажиллагаа



Энэхүү сургалтанд хамрагдсан оролцогчид ууланд баг ахлах эрхийг олон улсын стандартаар олж авах төдийгүй цаашид сургагч багш, эрх бүхий уулын хөтөч болон бэлтгэгдэх юм.

31. 9-р сарын 6-13

Монголын Уулчдын Үндэсний Холбоо болон Олон Улсын Уулын Холбоо /UIAA/-ны бүрэн эрхэт, идэвхтэй гишүүн билээ. Гишүүнчлэлийн хүрээнд олон улсын холбоотой хамтран олон чиглэлд үйл ажиллагааг хамтран зохион байгуулж байна. Холбооны 2016-2020 оны стратеги зорилтууд энэ оны байдлаар 80-аас дээш хувьтай биелж байна, тухайлбал Холбооны шүүгчдийн зөвлөлийн дарга С.Дэлгэрмөрөн нь Олон Улсын Уулын Холбоо /UIAA/-оос хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын шүүгчдийн жагсаалтанд Монгол улсаа төлөөлөн албан ёсоор орлоо.



32. 9-р сарын 21

Хайрхан Аялагч Клуб, Монголын уулчдын үндэсний холбоо жил бүр уламжлал болгон албан ёсоор зохион байгуулдаг Гарамын Барсболд нэрэмжит Уулын Клубуудийн хоорондох Уулын Эрчимт Алхалтын Тэмцээн маань өргөжин тэлж 2019 оноос Уулын Эрчимт Алхалтын Улсын Аварга Шалгаруулах Анхдугаар Тэмцээн болгон зохион



байгуулагдаж байна. Энэ анхдугаар тэмцээн нь 2019.09.21-ны өдөр Богд Хан Уулын Манзуширийн хийдээс Зайсангийн ам хүртэл 17.5км зайд 7 хүний бүрэлдэхүүнтэй багаар уралдсан ба нийт 15 клубын 182 тамирчин ороцлоо.



№	Гэгдэл	Байршил	Тамирчдын дугаар	Гарамны цаг	Харамны цаг	Ниссэн цаг	Байр
1	гараа 6	Төгрөг	10-161	10:42:00	0:25:00	2:43:33	2-р байр
2	гараа 6	Хайрхан Аялагч Клуб-6	1-7	10:42:00	0:25:00	2:50:43	3-р байр
3	гараа 1	УБ хайлагч клуб-1	43-49	10:17:00	0:00:00	2:30:56	4-р байр
4	гараа 1	Хархсан Аялагч Клуб-4	20-26	10:17:00	0:00:00	2:38:12	5-р байр
5	гараа 6	Хайрхан Аялагч Клуб-2	8-14	10:42:00	0:25:00	3:07:07	6-р байр
6	гараа 6	И.Н. Монгол	85-91	10:35:00	0:15:00	3:04:21	7-р байр
7	гараа 7	Халдунд ажиллагаа клуб-4 -Цооног нэрээ	143-154	10:47:00	0:30:00	3:24:49	8-р байр
8	гараа 5	Хайрхан Аялагч Клуб-3	36-42	10:37:00	0:20:00	3:15:42	9-р байр
9	гараа 5	УБ хайлагч клуб-2	60-66	10:37:00	0:20:00	3:29:26	10-р байр
10	гараа 3	Монгол уулчдын клуб-4	162-168	10:27:00	0:10:00	3:13:04	11-р байр
11	гараа 8	Энх Агуу клуб	62-68	10:52:00	0:35:00	3:49:06	12-р байр
12	гараа 2	Халдунд ажиллагаа клуб	113-119	10:37:00	0:20:00	3:45:20	13-р байр
13	гараа 7	УБ хайлагч клуб-3	67-73	10:47:00	0:30:00	3:54:26	14-р байр
14	гараа 4	Хан хайлагч клуб-1	99-105	10:32:00	0:15:00	3:30:19	15-р байр
15	гараа 2	Халдунд ажиллагаа клуб	176-182	10:47:00	0:30:00	4:01:46	16-р байр
16	гараа 5	Хайрхан Аялагч Клуб-4	71-77	10:57:00	0:40:00	4:16:12	17-р байр
17	гараа 3	Халдунд ажиллагаа клуб-3 -Цооног	124-140	10:57:00	0:40:00	4:26:29	18-р байр
18	гараа 6	Хархсан Аялагч Клуб-2	29-35	10:52:00	0:35:00	4:33:00	19-р байр
19	гараа 1	Их Орхонд клуб	78-84	10:17:00	0:00:00	3:51:46	20-р байр
20	гараа 4	ХУУ хайлагч клуб	64-70	10:32:00	0:15:00	4:10:22	21-р байр
21	гараа 8	Тэнгэр уулчдын клуб	120-126	10:52:00	0:35:00	4:31:18	22-р байр
22	гараа 2	Халдунд ажиллагаа клуб-3 -Цооног	141-147	10:22:00	0:05:00	4:14:44	23-р байр
23	гараа 5	Монгол уулчдын клуб-2	169-175	10:22:00	0:05:00	4:27:29	24-р байр
24	гараа 3	Халдунд ажиллагаа клуб-4 -Цооног	127-133	10:27:00	0:10:00	5:42:30	25-р байр
25	гараа 2	Хан хайлагч клуб-2	106-112	10:22:00	0:05:00		26-р байр
26	гараа 3	Оюу толгой ажиллагчдын баг	15-21	10:27:00	0:10:00		27-р байр

Тэмцээнийг зохион байгуулах
НОМИС
2019

33. 9-р сарын 19-23

Монголын уулчдын үндэсний холбоо Онцгой байдлын ерөнхий газрын албан хаагчидтай хамтран "СУТАЙ" хайрханд Өндөр ууланд эрэн хайх, аврах ажиллагааны сургалт зохион байгууллаа. Онцгой байдлын ерөнхий газраас Монгол уулчдын үндэсний холбоотой хамтран өндөр ууланд эрэн хайх, аврах ажиллагааны “УЭХАА-19.1” сургалт дадлагыг Говь-Алтай аймгийн Тонхил сумын нутагт орших Сутай ууланд энэ сарын 18-23-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэ үеэр Онцгой байдлын байгууллагын 38 алба хаагч, Монголын уулчдын үндэсний холбоо болон Тонхил суманд байрлах “Сутайн бор” клубын тамирчидтай хамтран Сутай уулын оргилд 4205 метрийн өндөрт авиралт, болон сургалт хийсэн.





34. 09-р сарын 26

Монголын уулчдын үндэсний холбоо нь менежментийн багтаа 76 идэвхтэй сайн дурын гишүүдтэй билээ. Хайкин Хороо нь 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу #БогдХанУулын Жаргалантын амнаас Бидний хэлж заншсанаар #ДугуйЦагаан хүртлэх замд тэмдэглэгээ тавих ажлыг хийж гүйцэтгэлээ



35. 10-р сарын 02

Олон Улсын Уулчдын Холбоо/ОУУХ/-ны Өндөр уулын авиралтын комисс /ӨУАК/-ын дарга Питер Фааркаш 2019 оны 9 дүгээр сарын 29-ний Ням гаригт Улаанбаатарт хүрэлцэн ирэв. Олимпизмын үзэл санааг дэлгэрүүлэх, МУҮХ ба ОУУХ хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмрийг нь ийнхүү өндөрөөр үнэлж тус шагналыг олгосныг Монголын Үндэсний Олимпийн Хороо/МҮОХ/-ны Ерөнхийлөгч Д.Загдсүрэнгийн шийдвэрээр Олон Улсын Уулчдын Холбоо/UIAA/-ны Өндөр уулын авиралтын комиссын дарга Питер Фааркашийг МҮОХ-ны АЛТАН МЕДАЛИАР шагналаа.





36. 10-р сарын 08

Монголын Уулчдын Үндэсний Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, Цол зэргийн зөвлөлийн дарга Б.Гангаамаа өөрийн уулчдыг дэмжих "Гангаамаа сан" хүрээнд "Алтай Актру" сургалтын баазтай хамтран ОХУ-ын Алтайн Бүгд Найрамдах Улс Хойд Чуйгийн нурууны ноён оргил Актру - Баш 4074 м ууланд болсон "Актру 2019" хамтарсан сургалт авиралтыг ОХУ-ын уулын гавьяат аврагч "Алтай Актру" сургалтын баазын захирал Валерий Якубовскийн удирдлаган дор 2019 оны 9 сарын 21-ээс 27-ны хооронд амжилттай зохион байгуулаад ирлээ. Энэхүү сургалтанд Монголын уулчдын үндэсний холбооны төлөөллүүд, Монголын уулчид, уулын клубууд идэвхитэй оролцож амжилтаа ахиулаад ирсэн билээ.



37. 10 сарын 13

НЭГ-УУЛЧИН, НЭГ-УУТ ХОГ” АЯН

Хоггүй Цэвэрхэн Монгол аяны хүрээнд Монголын Уулчдын үндэсний холбоо, Нийслэлийн Байгаль орчны газар хамтран хүрээлэн буй орчны хог хаягдлыг цэвэрлэх тэр дундаа уулчид хол байгаа, тэр бүр хүмүүс очиж цэвэрлээд байдаггүй хогийг цэвэрлэх уриалган дор "Нэг-уулчин, Нэг-уут хог" аяныг аравдугаар сарын 13-ны ням гарагт Богдхан уулын Манзуширын хийд орчимд зохион байгууллаа. Тус аянд өнөөдөр оролцогч 13-н байгууллага, 16 уулын клуб болон хувь хүн нийт 136 хүн оролцож 146 шуудай хог буулгаж Байгаль Эх дэлхийгээ цэвэрлэх үйлсэд гар бие оролцлоо.



38. 10 сарын 12

Азийн уулын холбооны чуулганд МУҮХ-г төлөөлөн Дэд Ерөнхийлөгч С.Алдархишиг оролцлоо. Азийн уулын холбооны жил бүрийн тайлангийн хурал Киргизийн Бишкек хотод 10 сарын 12нд болсон. Холбооны 2019 онд хийсэн үйл ажиллагааны тайланг тавьсан.



39. 11 сарын 1-3

Олон Улсын Уулчдын Холбоо (UIAA - International Climbing and Mountaineering Federation)-ны 2019 оны ээлжит Ерөнхий ассамблей Кипр улсын Ларнака хотод амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Ерөнхий ассамблейд Монголын Уулчдын Үндэсний Холбоог төлөөлж Ерөнхийлөгч Буяагийн Тулга, Дэд ерөнхийлөгч Б.Золжаргал, Санхүү, хөрөнгө оруулалтын хорооны дарга Н.Дөл-Эрдэнэ, Мөсөнд авиралтын хорооны гишүүн Г.Батбаяр нар оролцлоо. Удирдах зөвлөл нь нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй ба энэ жил 3 хүн чөлөөлөгдөж, түүнд дараах гишүүдийг шинээр сонгосноор Ази тивээс 3 төлөөлөл Удирдах зөвлөлийн түүхэнд анх удаа орсон нь энэ жилийн Ерөнхий ассамблейн онцлох үйл явдал байлаа.

Үүнд:



1. Лоүд Бэккэрс - Белгийн Уулын Холбоо
2. Банзрагчийн Золжаргал - Монголын Уулчдын Үндэсний Холбоо
3. Махмууд Хашеми - Ираны уулын болон спорт авиралтын холбоо



40. 11 сарын 22

Монголын Уулчдын Үндэсний Холбоо болон Хятадын Уулын Холбооны найрсаг харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсаас Уулын цанын спортын төрлөөр тамирчин, дасгалжуулагчийг БНХАУ-д бэлтгэх сургалтанд хамруулах сонгон шалгаруулалтыг зарласан билээ. 2019/11/21-ны өдөр МУҮХ байранд Монголын Уулчдын Үндэсний холбооны Ерөнхийлөгч Б.Тулга, Дэд Ерөнхийлөгч С.Алдархишиг, Дэд Ерөнхийлөгч Б.Золжаргал, Уулын цанын хорооны дарга, Н. Дөл-Эрдэнэ нар Сонгон шалгаруулалтад тэнцсэн А.Анар-эрдэнэ Н.Эрхсаран нарыг хүлээн авч уулзав.





41. 11 сарын 23

“Улаанбаатар Залуусын Оролцоо” ТББ-ын дэргэдэх “Улаанбаатар Аялагч” клуб нь Монголын Уулчдын Үндэсний Холбоотой хамтран өөрийн клубийн нэрэмжит бага насны хүүхдүүдийн дунд зохиогддог спорт авиралтын тэмцээнийг 2019 оны 11 дүгээр сарын 24-ны Ням гараг 4 дэх удаагаа амжилттай зохион байгууллаа.



42. 11-р сарын 30 нд

МУҮХ-ны цол зэргийн зөвлөл ээлжит хуралаа хийлээ. Холбоо, клуб, тамирчидаас ирүүлсэн материалыг үндэслэн "АЛЬПИНАД 2019" оны уулчдын цугралтанд цол хамгаалах авиралт хийсэн зэргийг авч хэлэлцэн журмын дагуу болзол хангасан нийт 29 хүнд цол зэрэг олгов.

Үүнд: Спортын мастер -2, Дэд мастер-1, Нэгдүгээр зэрэг-9, Хоёрдугаар зэрэг-12, Гуравдугаар зэрэг- 5 тус тус олгов.

43. 12 сарын 1нд

МУҮХ-ны Хайкинг хорооны санаачилгаар Скайраннингийн хороотой хамтран өвлийн авиралтын улирлын Хэнтий нурууны ноён оргил АСРАЛТ хайрханд нэгдсэн авиралт зохион байгуулсанаар амжилттай болж өндөрлөлөө. Тус аялалын хүрээнд “АСРАЛТ УРАЛДААН 2019” ВЕРТИКАЛ КИЛОМЕТР СКАЙРАННИНГИЙН ТЭМЦЭЭНИЙГ туршилтын байдлаар анх удаа зохион байгуулсан.
ТУС ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО НЬ:



Уулын спортын нэг төрөл болох Скайраннингийг олон нийтэд сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, Уулын спортын энэхүү төрлөөр сонирхогч, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, улмаар үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, дасгалжуулах, Өндөр чансаатай тамирчдын ур чадварыг дээшлүүлэх ба дэлхий, тив, олон улсын тавцанд өрсөлдөх шилдэг тамирчдыг илрүүлэн сонгон шалгаруулах, залгамж халааг бэлтгэх, Тэмцээний удирдлага, зохион байгуулалтыг чанаржуулах, Уулын спортын клубуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх байлаа.

Уралдаанд нийтдээ 45 тамирчин бүртгүүлсэнээс гараанаас 41 тамирчин гарсан.



44. 12 сарын 3 нд

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 10-р сарын 9-ний өдрийн "Олон улсыг спортын наадам зохион байгуулах тухай" 376 дугаар тогтоолоор 2020 онд Олон улсын залуучуудын ногоон наадмыг Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2020 оны 9-р сарын 13-20-ны өдрүүдэд зохион байгуулахаар болсон. Уулын спортын нэг төрөл болох СПОРТ АВИАЛТ энэ наадмын 25 төрлийн спортод багтсан билээ.





45. 12 сарын 7-8 нд

Монгол экспедишн ХХК /Ерөнхий зохион байгуулагч/, Монголын Уулчдын үндэсний холбоо, БОАЖЯ,Өвөрхангай аймгийн ЗДТГ-тай хамтран Мөсөнд авиралтын спортыг таниулах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, мөн өвлийн аялал жуулчлалыг дэмжих зорилготойгоор энэхүү "Хархорин 2019" Мөсний фестивалийг Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын нутагт байрлах Улаан цутгалангийн хүрхрээнд амжилттай зохион байгуулагдаа. Уг тэмцээний тамирчдын аюулгүй байдлыг хангаж Амар даатгал ХХК, тэмцээнд оролцсон тамирчид болон, үзэгчдэд тусгай гарын бэлэг гардуулж уул, аялалын хувцасны LOWO брэнд тус тус хамтран ажиллалаа.





46. 12 сарын 09-13 нд

Олон Улсын Олимпийн Хорооны Эв санааны нэгдлийн хөтөлбөрийн хүрээнд Монголын Үндэсний Олимпийн Хороо Монголын Уулчдын Үндэсний Холбоонд Спорт авиралтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн Спорт авиралтын сургагч багш-дасгалжуулагч бэлтгэх сургалт Улаанбаатар хотод 2019/12/09-11 нийг дуустал явагдаж байна. Сургалтыг ОХУ-ын нэрт дасгалжуулагч С.Сергей, ОХУ-ын алдартай тамирчин-дасгалжуулагч С.Кокорин нар удирдан явуулж байна. Танхимын болон заалны сургалт хослон явагдах юм. Манай улсаас орон нутгаас 9, Улаанбаатар хотоос 13, нийт 20 дасгалжуулагч багш нар хамрагдаж байна.



47. 12 сарын 13 нд

"БӨРТЭ ЧОНО 2019"

Монголын Үндэсний Олимпийн Хорооны Тэргүүн дээд шагнал гардуулах БӨРТЭ ЧОНО 2019 наадмын “Шилдэг хөрөнгө оруулалттай холбоо” номинацид Монголын Уулчдын Үндэсний Холбооноос нэр дэвшсэн Говь-Алтай аймгийн Тонхил суман дахь Уулын спортын ууган мастер Я.Жанцангийн нэрэмжит “Сутайн бор” клубын ОЛИМП Спорт авиралтын төвийн бүтээн байгуулалтын ажил шалгарлаа.





Үйл ажиллагааны тайлан

48. Монголын Уулчдын Үндэсний Холбооны 2016-2019 оны бүтэн 4 жилийн үйл ажиллагааны үр дүнг танилцуулах, 2020-2024 оныг угтах АЛТАН ҮДЭШ хүндэтгэлийн цэнгүүнийг амжилттай зохион байгуулав.

МОНГОЛЫН УУЛЧДЫН
ҮНДЭСНИЙ ХОЛБОО

GOLDEN NIGHT 2020

Dress code: **#GOLDEN GENTLEMAN**

Үндэсний Соёл
Амралтын хүрээлэн
WHITE ROCK CENTER

2019.12.30-нд 18:00 цагт
RSVP: 9916-8082



МОНГОЛЫН УУЛЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО 2020 ОНЫ ТАЙЛАН

1. 1-р сарын 3-5

БНХАУ-ын Жилин мужийн Чанчун хотноо Мөсөнд авиралтын дэлхийн цомын эхний цуврал тэмцээнд оролцолоо. Багийн бүрэлдэхүүнд Сутайн бор клубын тамирчин Азийн аварга шалгаруулах тэмцээний мөнгөн медальт ОУХМ Н.Хэрлэн, мөн клубын тамирчин спортын дэд мастер Б.Ариунбаяр, спортын I зэрэгтэй тамирчин Ж.Сэдэд, Хайрхан аялагч клубын тамирчин спортын дэд мастер Д.Баасандорж нар оролцов

Өмнөд хөршид 3 дахь удаагаа болж буй энэхүү тэмцээнд оролцохоор 16 орны 80 гаруй тамирчид оролцосон. Олон Улсын Уулын Холбооны дэд ерөнхийлөгч, МУҮХ-ны тэмцээнт төрөл хариуцсан дэд ерөнхийлөгч Б.Золжаргал уг тэмцээнийг нээлт хийсэн.





2. 01 сарын 5-6 нд

ОХУ-ын Эрхүү хотод зохиогдсон Горы Байкала клубын 2020 оны нээлтийн тэмцээн 2020 оны 01 сарын 5-6 ны хооронд амжилттай болж өндөрлөлөө. Тус тэмцээнд Монголын Уулчдын Үндэсний холбоо, Улаанбаатар аялагч клубын тамирчин Спортын мастер Ч.Мандахбаяр. Монголиан экспедишн компани тамирчин спортын Дэд мастер Д.Отгонхүү нар амжилттай оролцож

Хурдны төрөлд:

СМ Ч.Мандахбаяр 1-р байр

Дэд мастер Д.Отгонхүү 2-р байр

Техникийн төрөлд:

Дэд мастер Д.Отгонхүү 3-р байр

СМ Ч.Мандахбаяр 4-р байр тус тус
ЭЗЭЛСЭН.



3. 01-р сарын 09 нд

Монголын Уулчдын Үндэсний Холбоо Нийслэлийн Байгаль Орчны Газартай хамтран Улаанбаатар хотын байгаль орчныг хамгаалах, Улаанбаатар хот орчмын ой мод, ногоон байгууламжын бүс булаг шанд, голын эх хамгаалал, уулын алхалтын жим, маршрут гаргах, байгаль хамгаалагч нарт сургалт зохион байгуулах, байгаль хамгаалал зэрэг болон бусад хамтын ажиллагааг үүсгэх хамтран хийх өргөжүүлэх зорилгоор хамтын ажиллагааны санамж бичиг зурлаа.

ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ

- Олон Улсын Уулчдын Холбоо (UIAA-international Climbing and Mountaineering Federation)-ны Уул хамгааллын чиглэлд хийгддэг төсөл хөтөлбөр шалгаруулдаг Mountain Protection Awards уралдааны удирдамжийн хүрээнд 1990 оноос хойш модны хулгайд өртөж модны ихэнх хувийг алдсан “Баянзүрх Хайрханд” УУЛЧДЫН ТӨГӨЛ байгуулах.
- Улаанбаатар хотын усны хангамжын эх үүсвэрийг бүсэд мод тарих



Үйл ажиллагааны тайлан

- Улаанбаатар хот орчмын байгаль хамгааллын ногоон бүсэд байх гол, булаг шандны эхийг хамгаалах ажилд хамтран ажиллах
- Нийслэлийн оршин суугчид, аялагч алхагч нарт зориулсан алхалтын жим (хайкинг трайл) гаргах аялалын клубуудэд таниулах газрын зурагжуулах, тэмдэглэгээ хийхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж хамтран ажиллахаар боллоо.



4. 01-р сарын 10-11

Монголын Уулчдын Үндэсний Холбооны баг тамирчид ОУУХ/UIAA/-ноос БНСУ, Чонгсонд Мөсөнд авиралтын дэлхийн цомын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож Монгол улсаас анх удаа Ази тивийн хоёр шинэ аварга төрсөн билээ. Чонгсоны тэмцээн нь Дэлхийн цом, Азийн аварга гэсэн хосломол тэмцээн болж буй бөгөөд онооны жагсаалтаар



Үйл ажиллагааны тайлан

- ОУХМ Н.Хэрлэн 17.45
оноотойгоор Азийн
аваргын АЛТАН медаль
/хурд,эр/
- Спортын мастер
Б.Ариунбаяр 24.06
оноотойгоор Азийн
аваргын АЛТАН медаль
/хурд , эм/
- Спортын дэд мастер
Д.Баасандорж 20.95
оноотойгоох Азийн
аваргын ХҮРЭЛ медаль
/хурд, эр/
- Дэд мастер Д.Отгонхүү
8-р байр,/хурд,эр/
- Спортын мастер Ч.
Мандахбаяр 16-р /хурд,
эр/ байранд тус тус
шалгарсан билээ.



Мөсөнд авиралтын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд Монголын баг тамирчид багийн дүнгээр II байр эзэлсэн том амжилттай ганзага дүүрэн тэмцээнээ






5. 01-р сарын 23 нд

Монголын Уулчдын үндэсний холбооноос жил бүр уламжлагдан зохион байгуулдаг "ICE CHALLENGE MONGOLIA 2020" Мөсөнд авиралтын Улсын аварга шалгаруулах тэмцээн, Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн Олон улсын хүүхдийн "Найрамдал" цогцолборт хийдэг билээ. Тэмцээний мөсөн ханын угсралтын ажлыг МУҮХолбооны санхүүжилтээр Сутайн бор"клубын тамирчин, Спортын мастер О.Сайханжаргалаар ахлуулан X team залуус маш амжилттай хийж гүйцэтгэж дууслаа.



6. 10-р сарын 2 нд

Монголын Уулчдын Үндэсний холбоо, МУИС Биеийн тамирын тэнхимтэй хамтарч Биеийн тамирын хичээлд сонгон суралцах боломжтойгоор Спорт авиралтын хичээл дээр хамтарч ажиллаад 2 жил болж байна. 2019 онд МУИС-ын Биеийн тамирын тэнхим хамтарч ажиллаж буй спортын холбоодтой хамтарч "Биеийн Тамир" сурах бичиг гаргасан билээ. Уг номын 10 дугаар бүлэгт Уулын спортын нэг төрөл болох "Спорт авиралт"-ын төрөл маань орсон. Энэхүү номын спорт авиралтын тухай хэсгийг Монголын Уулчдын Үндэсний Холбооны тэмцээнт төрөл хариуцсан дэд Ерөнхийлөгч Б.Золжаргал, Спорт авиралт, хаданд авиралтын хорооны гишүүн Б.Ундармаа нар хамтран гүйцэтгэсэн





7. 11-р сарын 08 нд

Улаанбаатар Аялагч клуб нь бага насны хүүхдийн ханан авиралтын тэмцээнийг 5 дахь удаагаа зохион байгуулах гэж байна. Тэмцээний зорилго нь бага насны хүүхдийн бие бялдар болон оюун санааны хөгжилд хувь нэмэр оруулах, улмаар улсын чанартай тэмцээн болж хөгжих, мөн ханан авиралтын спорт нь Олимпын төрөлд багтсан спорт тул ирээдүйн Монгол улсаас Олимпын тамирчин төрүүлэхэд оршино.



8. 11-р сарын 12-13

Монголын Уулчдын Үндэсний Холбооны Цол зэргийн зөвлөлийн хурал “КОВИД-19” цар тахал гарч, онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор анх удаа цол зэргийн зөвлөл цахимаар хуралдаж тамирчдын цол зэрэг горилж ирүүлсэн материалыг авч хэлэлцэв.

Материал ирүүлсэн тамирчдаас:

- Олон улсын хэмжээний мастер 2 тамирчин
- Спортын Мастер 2 тамирчин
- Дэд мастер 1 тамирчин
- 1 дүгээр зэрэгтэй 4 тамирчин
- 2 дугаар зэрэгтэй 3 тамирчин
- 3 дугаар зэрэгтэй 8 тамирчин тус тус төрж нэг тамирчны норматив горилсон зэрэгтээ хүрээгүй тул буцаагдав.



МОНГОЛЫН УУЛЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО 2021 ОНЫ ТАЙЛАН

1. 2021 он

Олон улсын уулын холбооны санаачлагаар Петцл сангийн гарсан Уулчдын гарын авлагыг Олон Улсын Уулын Холбоо (UIAA)-ны Дэд ерөнхийлөгч, МУҮХ-ны Дэд ерөнхийлөгч Б.Золжаргалын Монгол хэлрүү хөрвүүлэх санаачлагын дагуу МУҮХ-ны Ерөнхийлөгч Б.Тулгагын ахалсан баг амжилттай орчуулж дуусгасан. 2021 онд номын эх бэлтгэл, хэвлэлтэн дээр илүү анхаарч ажиллаа.



Монгол хэлрүү хөрвүүлэх төслийн санаачлагч: Олон Улсын Уулын Холбоо (UIAA)-ны Дэд ерөнхийлөгч, МУҮХ-ны Дэд ерөнхийлөгч Б.Золжаргал
Монгол хэлрүү хөрвүүлэх төслийн удирдагч: МУҮХ-ны Ерөнхийлөгч Б.Тулга
Монгол хэлрүү хөрвүүлсэн: Ө.Буяндэлгэр, Г.Мөнхжаргал, Ө.Өлзийхүү, Х.Халиун
Техникийн орчуулга: Г.Мөнхсайхан, Б.Батболд
Дахин хянасан: МУҮХ-ны Сургалт, Аюулгүй Ажиллагааны хорооны дарга Г.Мөнхжаргал
Монгол хэлний редактор: Хэл бичгийн ухааны доктор, дэд профессор О.Шинэбаяр
Зургийн баг: Б.Бат-Эрдэнэ / Төгөл
Эх бэлтгэл: А.Дөлгөөн



2. 12-р сарын 11-нд

Монголын Уулчдын Үндэсний Холбооны Цол зэргийн зөвлөлийн хурал хуралдаж тамирчдын цол зэрэг горилж ирүүлсэн материалыг авч хэлэлцэв.

Материал ирүүлсэн тамирчдаас:

- Олон улсын хэмжээний мастер 2
- Спортын Мастер 2
- Дэд мастер 4 тамирчин
- Уулын спортын 1-р зэрэг – 2
- Уулын спортын 2-р зэрэг - 8
- Уулын спортын 3-р зэрэг – 8 тус тус төрж таван хүний материал норматив горилсон зэрэгтээ хүрээгүй тул буцаагдав.

3. 12-р сарын 24-нд

Монголын Уулчдын үндэсний холбооноос жил бүр уламжлагдан зохион байгуулдаг "ICE CHALLENGE MONGOLIA 2020" Мөсөнд авиралтын Улсын аварга шалгаруулах тэмцээн, Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборт хийдэг билээ.

МУҮХ-ны дэмжлэгтэй Хоризон клуб, ХАЙРХАН аялагч клуб, Мазаалай Аялагч клуб Их оргилдын залуучууд нэгдээд ковидын хэцүү цаг үед маш бага зардлаар мөсөнд авиралтын ОУ-ын тэмцээнд явах тамирчдын бэлтгэл хийх ханыг хийж дуусгалаа.





4. 2022 оны 1-р сарын 26-28

Швейцарь, Саас-Фэ хотод зохион байгуулсан Мөсөнд авиралтын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд манай баг тамирчид амжилтай оролцож эрэгтэй хурдны төрөлд багийн оноогоор 3-р байр эзэлсэн

Багийн бүрэлдэхүүнд:

СМ- Б.Ганзориг Дасгалжуулагч

ОУХМ- Н.Хэрлэн

ОУХМ-Д.Баасандорж

СМ- Ч.Мандахбаяр

СМ- Д.Отгонхүү

СМ- Ө.Цогтбаяр





Монголын уулчдын холбооны гишүүн клубууд

1. Mongolian mountain summit
2. Энхжингийн цэцэрлэг төгөлт хүрээлэн
3. Улаанбаатар аялагч клуб
4. Хайрхан аялагч клуб
5. Хязгааргүйд мац клуб
6. RTU клуб
7. Хамтдаа Алхацгаая Клуб
8. JCI Hiking клуб
9. Тэнгэр уулчдын клуб
10. ЖАРГАЛАНТ уулчдын клуб
11. Хөх тэнгэр аялагч клуб
12. Тэгри аялагч клуб
13. Эрүүл Монгол хайкинг клуб
14. Сутайнбор клуб
15. Мазаалай клуб
16. Хаан алхалт клуб
17. Саммит клуб
18. Номадик клуб
19. MONGOLAN EXPEDITIONS
20. Эрдэнэт уулчдын холбоо
21. SNOWBOARD-Н ХОЛБОО
22. УВС АЙМАГ СПОРТ АВИРАЛТЫН ХОЛБОО
23. Хамтдаа хайкинг клуб
24. Дархан хайкинг клуб
25. Эко агула клуб
26. Жаал хайкинг клуб
27. Хоризон клуб
28. Хэт холын зайн гүйлтийн холбоо
29. Жой хайкинг клуб
30. Дархан найрамдал клуб
31. KB HIKING клуб
32. Монголын эрүүл мэндийн гүйлтийн холбоо
33. Ууланд алхагчид клуб
34. Гангаамаа сан
35. Спортын мастеруудын холбоо
36. АПУ хайкинг клуб
37. Их Оргилд клуб